



**“ЖИРЭМСЭН БОЛОН ТӨРСНИЙ ДАРААХ ҮЕИЙН СЭТГЭЛ ГУТРАЛ ТҮҮНД  
НӨЛӨӨЛӨХ ЗАРИМ ЭРСДЭЛТ ХҮЧИН ЗҮЙЛСИЙГ ТОГТООХ ”**

**СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

Улаанбаатар

2022

## **ТАЛАРХАЛ**

Жирэмсэн болон төрсний дараах үеийн сэтгэл гутрал түүнд нөлөөлж буй хүчин зүйлийн судалгааг хийхэд дэмжлэг үзүүлсэн Эрүүл мэндийн сайд С. Энхболд, Нийтийн эрүүл мэндийн газрын дарга Д.Баярболд нарт талархсанаа илэрхийлье. Мөн судалгааг зохион байгуулахад өөрсдийн туршлага, санал бодлоо бидэнтэй хуваалцаж дэмжлэг үзүүлсэн СЭМҮТ-ийн Удирдлагын баг, НЭМЭШСГХ-СТСМТА-ны хамт олон, Нийслэлийн Өргөө амаржих газрын хамт олон, АШУУИС-ын Төв эмнэлэг, АУС-ийн Сэтгэцийн эрүүл мэндийн тэнхим, Дотоод шүүрэл судлалын тэнхим, санхүүгийн дэмжлэг үзүүлсэн Эрүүл мэндийн яамны Эрүүл мэндийг дэмжих сангийн хамт олон, сэтгэц судлалын резидент эмч нар, судалгаа авсан аймаг, дүүргийн сэтгэцийн эмч нар болон эх барих эмэгтэйчүүд, нөхөн үржихүйн зохицуулагч эмч нар, Эрүүл мэндийн газрын мэргэжилтнүүд, хороо, сумын эрүүл мэндийн төвийн эмч, нийгмийн ажилтан болон судалгаанд хамрагдсан нийт оролцогчиддоо талархал илэрхийлье.

### **ХАМТРАН АЖИЛЛАСАН БАЙГУУЛЛАГА, ХАМТ ОЛОН**

- Эрүүл мэндийн яам
- Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв
- Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль
- Нийслэлийн Өргөө Амаржих Газар
- Улсын гуравдугаар төв эмнэлэг
- Гранд мед эмнэлэг
- Аймгийн эрүүл мэндийн газрууд
- Бүсийн оношилгоо эмчилгээний төвүүд
- Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгүүд
- Дүүргийн эрүүл мэндийн төвүүд
- Сум, хорооны эрүүл мэндийн төвүүд

### **СУДАЛГААНЫ АЖЛЫН УДИРДАГЧ:**

Л.Насанцэнгэл, Анагаах ухааны доктор (Ph.D), Профессор, СЭМҮТ  
Т.Ганцэцэг, Анагаах ухааны доктор (Ph.D), АШУУИС

### **СУДАЛГААНЫ АЖЛЫН ЗӨВЛӨХ:**

Ж.Энхцэцэг, Анагаах ухааны доктор (Ph.D), Профессор, Нийслэлийн Өргөө Амаржих Газар  
Х.Алтайсайхан, Анагаах ухааны доктор (Ph.D), Профессор, АШУУИС  
Д.Мягмарцэрэн, Анагаах ухааны доктор (Ph.D), Дэд профессор, АШУУИС  
Б. Батзориг, НЭМУ-ны доктор (Ph.D), НЭМС, НЭМХ

### **СУДАЛГААНЫ АЖЛЫН ЗОХИЦУУЛАГЧ:**

Л.Насанжаргал, Анагаах ухааны магистр, докторант, СЭМҮТ

М.Номин-Эрдэнэ, Анааах ухааны магистр, докторант, УГТЭ  
К. Елена, Анааах ухааны магистр, СЭМУТ

## **СУДАЛГААНД ОРОЛЦСОН СУДЛААЧИД:**

Л.Насанжаргал, Анааах ухааны магистр, докторант, СЭМУТ  
М.Номин-Эрдэнэ, Анааах ухааны магистр, докторант, УГТЭ  
З.Оргил, Анааах ухааны магистр, докторант, Гранд мед эмнэлэг, резидент эмч, СЭМУТ  
К. Елена, Анааах ухааны магистр, СЭМУТ  
Н.Ариунгэрэл, резидент эмч, СЭМУТ  
Б.Атарцэцэг, Нөхөн үржихүйн зохицуулагч эмч, СХДЭМТ  
Т.Баасанхүү, ЭМГ мэргэжилтэн, Төв аймаг  
В.Байгалмаа, НЭМЭШСГХ-СТСМТА-ны туслах ажилтан, СЭМУТ  
С.Байгалмаа, Анааах ухааны магистр, СЭМУТ  
Б.Батболд , Анааах ухааны магистр, СЭМУТ  
Д.Баттулга, сэтгэцийн эмч, Архангай аймгийн ЭМГ, нэгдсэн эмнэлэг  
Б.Батцэцэг, сэтгэцийн эмч, СЭМУТ  
О.Батчимэг, сэтгэцийн эмч, СЭМУТ  
Г.Баярмаа, сэтгэцийн эмч, СЭМУТ, Наркологийн эмнэлэг  
Х.Бумцэцэг, Эх барих эмэгтэйчүүдийн эмч, СХЭМТ  
Г.Ганхүү, сэтгэцийн эмч, СЭМУТ  
Ц.Загдсүрэн, ЭМГ мэргэжилтэн, Дундговь аймгийн ЭМГ, нэгдсэн эмнэлэг  
М.Золжаргал, резидент эмч, СЭМУТ  
С.Лувсандорж, резидент эмч, СЭМУТ  
Б.Лхагважав, резидент эмч, СЭМУТ  
Х.Маралгуа, резидент эмч, СЭМУТ  
Э.Мөнх, Анааах ухааны магистр, докторант, СЭМУТ  
Ч.Мөнхбаатар, Өрхийн менежер, СХДЭМТ  
С.Мөнх-Үндрал, Нөхөн үржихүйн зохицуулагч эмч, ЧДЭМТ  
Г.Нарантуяа, сэтгэцийн эмч, Өвөрхангай аймгийн ЭМГ, нэгдсэн эмнэлэг  
Д.Номин-Эрдэнэ, резидент эмч, СЭМУТ  
О.Номин-Эрдэнэ, ЭМГ мэргэжилтэн, Өмнөговь аймгийн ЭМГ, нэгдсэн эмнэлэг  
Л.Одончимэг, эмэгтэйчүүдийн эмч, СХДНЭ  
В.Баярмаа, Анааах ухааны доктор (Ph.D), СЭМУТ  
Н.Оюунчимэг, докторант, СЭМУТ  
О.Оюунтөгс, Сувилахуй ухааны магистр, СЭМУТ  
Д.Одончимэг, докторант, СЭМУТ  
Э.Орхон, резидент эмч, СЭМУТ  
Б.Отгонжаргал, Анааах ухааны магистр, резидент эмч, СЭМУТ  
Ч.Очгэрэл, Анааах ухааны магистр, Лабораторийн эмч, СЭМУТ  
Н.Оюу-Эрдэнэ, резидент эмч, СЭМУТ

Л.Өсөхжаргал, Сэтгэцийн эмч, ЭМТУЧАБА-ны дарга, БОЭТ, Өмнөговь аймгийн ЭМГ, нэгдсэн эмнэлэг  
Т.Саранцэцэг, Анааах ухааны магистр, СЭМУТ  
Э.Тамир, НЭМЭШСГХ-СТСМТА-ны нийгмийн ажилтан, СЭМУТ  
Г.Урангэрэл, Сэтгэц эрүүл мэнд, донтох эмгэг, тандалт хариуцсан мэргэжилтэн, Дорнод аймгийн ЭМГ, БОЭТ  
Н.Ундармаа, Эх барих эмэгтэйчүүдийн эмч, Дорнод аймгийн ЭМГ, БОЭТ  
М.Уранчимэг, резидент эмч, СЭМУТ  
М.Үржинханд, сэтгэцийн эмч, ЭМГ-ын дарга, Завхан аймгийн ЭМГ, Нэгдсэн эмнэлэг  
Т.Хатанхүү, Сэтгэцийн эмч, Өмнөговь аймгийн ЭМГ, БОЭТ  
П.Хосбаяр, сэтгэцийн эмч, Ховд аймгийн ЭМГ, нэгдсэн эмнэлэг  
П.Хүрэлчимэг, Эх барих эмэгтэйчүүдийн эмч, Дорнод аймгийн ЭМГ, БОЭТ  
Б.Хулан, резидент эмч, СЭМУТ  
Г.Эгэлмарал, резидент эмч, СЭМУТ  
П.Энхбулган, резидент эмч, СЭМУТ  
Н.Энхмэнд, ЭМГ мэргэжилтэн, Хэнтий аймгийн ЭМГ, Нэгдсэн эмнэлэг  
Ч.Энхчимэг, сэтгэл зүйч, СЭМУТ  
М.Эрдэнэмэнх, резидент эмч, СЭМУТ  
Л.Эрдэнэсууд, Анааах ухааны магистр, СЭМУТ  
С.Эрдэнэчимэг, Нөхөн үржихүйн зохицуулагч эмч, БЗДЭМТ  
Х.Эрхцэцэг, Анааах ухааны магистр, СЭМУТ

**ЧИНГЭЛТЭЙ, БАЯНЗУРХ ДҮҮРГИЙН ТӨРСНИЙ ДАРААХ КОГОРТ СУДАЛГААНД ОРОЛЦСОН СУДЛААЧИД:**

З.Оргил, Анааах ухааны магистр, докторант, Гранд мед эмнэлэг, резидент эмч, СЭМУТ  
М.Номин-Эрдэнэ, Анааах ухааны магистр, докторант, УГТЭ  
Ц.Алтангэрэл резидент эмч, СЭМУТ  
С.Алтанхуяг резидент эмч, СЭМУТ  
А.Анхчимэг резидент эмч, СЭМУТ  
Н.Бадамсүрэн резидент эмч, СЭМУТ  
Б.Баярзул резидент эмч, СЭМУТ  
Б.Баярцэнгэл резидент эмч, СЭМУТ  
Б.Баясгаланмаа резидент эмч, СЭМУТ  
О.Дэнсмаа резидент эмч, СЭМУТ  
Ө.Золзаяа резидент эмч, СЭМУТ  
Ц.Насанжаргал резидент эмч, СЭМУТ  
Б.Номин-Эрдэнэ резидент эмч, СЭМУТ  
Н.Сэрчмаа резидент эмч, СЭМУТ

Г.Уранчимэг резидент эмч, СЭМҮТ  
Б.Уртнасан резидент эмч, СЭМҮТ  
Г.Хулан резидент эмч, СЭМҮТ  
Э.Шүрэнчимэг резидент эмч, СЭМҮТ  
Б.Энхжин резидент эмч, СЭМҮТ  
С.Энхчимэг резидент эмч, СЭМҮТ  
Э.Эрдэнэсувд резидент эмч, СЭМҮТ

**СУДАЛГААНЫ ТАЙЛАН БИЧСЭН:**

Л.Насанжаргал, Анагаах ухааны магистр, докторант, СЭМҮТ  
М.Номин-Эрдэнэ, Анагаах ухааны магистр, докторант, УГТЭ  
Л.Насанцэнгэл, Анагаах ухааны доктор (Ph.D), Профессор, СЭМҮТ  
Т.Ганцэцэг, Анагаах ухааны доктор (Ph.D), АШУҮИС

**АНГЛИ ХЭЛНЭЭ ОРЧУУЛСАН:**

Л.Насанцэнгэл, Анагаах ухааны доктор (Ph.D), Профессор, СЭМҮТ  
М.Номин-Эрдэнэ, Анагаах ухааны магистр, докторант, УГТЭ  
К. Елена, Анагаах ухааны магистр, СЭМҮТ

**ХЯНАН ТОХИОЛДУУЛСАН:**

Л.Насанцэнгэл, Анагаах ухааны доктор (Ph.D), Профессор, СЭМҮТ  
В.Баярмаа, Анагаах ухааны доктор (Ph.D), СЭМҮТ

## ГАРЧИГ

<b>ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ</b>	7
<b>ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ</b>	8
<b>ЗУРГИЙН ЖАГСААЛТ</b>	9
<b>ХУРААНГУЙ</b>	10
<b>НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. УДИРТГАЛ</b>	
1.1    Судалгааны ажлын үндэслэл	13
1.2    Судалгааны ажлын зорилго, зорилтууд	14
1.3    Судалгааны ажлын практик ач холбогдол	14
1.4    Судалгааны ажлын шинэлэг тал	14
1.5    Судалгааны таамаглал	14
1.6    Судалгааны ажлын ёс зүй	15
<b>ХОЁРДУГААР БҮЛЭГ. ХЭВЛЭЛИЙН ТОЙМ</b>	16
<b>ГУРАВДУГААР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ ХЭРЭГЛЭГДЭХҮҮН БА АРГА ЗҮЙ</b>	
3.1    Судалгааны загвар	21
3.2    Судалгааны хамрах хүрээ	21
3.3    Судалгаанд оролцогчдыг хамруулах болон хасах шалгуур	22
3.4    Судалгааны хэрэглэгдэхүүн ба мэдээлэл цуглуулсан арга	22
3.5    Судалгааны үр дүнгийн боловсруулалт	23
<b>ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ ҮР ДҮН</b>	
4.1    Хүн ам зүйн ерөнхий үзүүлэлт	24
4.2    Сэтгэл гутралын тархалт	30
4.3    Сэтгэл гутрал үүсэхэд нөлөөлөх зарим эрсдэлт хүчин зүйлс	35
<b>ТАВДУГААР БҮЛЭГ. ХЭЛЦЭМЖ</b>	38

<b>ДҮГНЭЛТ</b>	41
<b>ЗӨВЛӨМЖ</b>	42
<b>НОМ ЗҮЙ</b>	43
<b>ХАВСРАЛТ</b>	49

## **ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ**

АНУ	Америкийн нэгдсэн улс
БНХАУ	Бүгд найрамдах хятад ард улс
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
СЭМҮТ	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв
НЭМЭШСГХ-ТСМТА	Нийгмийн эрүүл мэнд, эрдэм шинжилгээ, сургалт гадаад харилцаа, танталт судалгаа, мэдээлэл технологийн алба
УБ	Улаанбаатар

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

<b>Хүснэгт 1</b>	Хүн ам зүйн ерөнхий үзүүлэлтүүд	24
<b>Хүснэгт 2</b>	Судалгаанд хамрагдсан эхчүүдийн жирэмслэлт ба төрөлттэй холбоотой үзүүлэлтүүд	26
<b>Хүснэгт 3</b>	Судалгаанд хамрагдсан эхчүүдийн удамзүй ба хорт зуршилтай холбоотой мэдээллүүд	27
<b>Хүснэгт 4</b>	Судалгаанд хамрагдсан эхчүүдийн гэр бүлийн харилцаа ба дэмжлэгийг судалсан байдал	28
<b>Хүснэгт 5</b>	Одоогийн хүчирхийлэлд өртөж буй байдлыг тодорхойлсон үзүүлэлтүүд	29
<b>Хүснэгт 6</b>	Сэтгэл гутралыг хүн ам зүйн үзүүлэлттэй харьцуулсан дүн	30
<b>Хүснэгт 7</b>	Сэтгэл гутралыг жирэмслэлт болон төрөлтийн үзүүлэлттэй харьцуулсан дүн	33
<b>Хүснэгт 8</b>	Гэр бүлийн харилцаа ба сэтгэл гутралын хоорондын хамаарлыг үнэлсэн үзүүлэлт	34
<b>Хүснэгт 9</b>	Биеийн жингийн индекс ба сэтгэл гутрал хоорондын хамаарлыг харьцуулсан дүн	34
<b>Хүснэгт 10</b>	Энгийн логистик регрессийн аргаар жирэмсэн эхчүүдийн сэтгэл гутралд нөлөөлж буй эрсдэлт хүчин зүйлийг судалсан дүн	35
<b>Хүснэгт 11</b>	Олон хүчин зүйлийн логистик регрессийн аргаар жирэмсний сэтгэл гутралд нөлөөлж буй эрсдэлт хүчин зүйлийг үнэлсэн үзүүлэлт	36

## **ЗУРГИЙН ЖАГСААЛТ**

- Зураг 1** Судалгаанд оролцогчдыг сонгож хамруулсан үйл явцын 21 зураглал
- Зураг 2** Судалгаанд хамрагдсан эхчүүдийн оршин сууж буй аймаг 26 дүүргийн харьяаллын үзүүлэлтүүд
- Зураг 3** Жирэмсэн эхчүүдийн сэтгэл гутралын (Эдинбургийн 30 асуумж) тархалт

## “ЖИРЭМСЭН БОЛОН ТӨРСНИЙ ДАРААХ ҮЕИЙН СЭТГЭЛ ГУТРАЛ ТҮҮНД НӨЛӨӨЛӨХ ЗАРИМ ЭРСДЭЛТ ХҮЧИН ЗҮЙЛСИЙГ ТОГТООХ” СУДАЛГААНЫ АЖЛЫН ХУРААНГУЙ

**Түлхүүр үг:** Жирэмсэн эх, амиа хорлох бодол, хүсээгүй жирэмслэлт

**Үндэслэл:** 2020 оны байдлаар дэлхий дээр 350 саяас илүү хүн сэтгэл гутрах эмгэгээр шанлаж байгаа бөгөөд эмэгтэйчүүд эрчүүдээс илүү сэтгэл гутралаар өвдөх эрсдэлтэй байдаг.<sup>1,2</sup> ДЭМБ-ын мэдээгээр сэтгэл гутрал нь 2020 оны нийт өвчлөлийн дотор хоёрдугаарт жагсаж байгаа нь<sup>3</sup> уг эмгэгийг зонхилон тохиолдох сэтгэцийн эмгэгийн нэг болохыг батлаад зогсохгүй хөгжиж байгаа улс орнуудын нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлын нэг болж байна.

Жирэмсэн эхчүүдэд өдрийн ихэнх цагт уйтгарлан гуних, итгэл найдвараа алдах, аливаа зүйлд сонирхолгүй болж, ядарч сульдах, нойрмоглох, хоолпох байдал нь өөрчлөгдөн, уурлаж уцаарлах, аз жаргалыг мэдэрч чадахгүй байх зэрэг шинжүүдээр илэрдэг эмгэгийг жирэмсэн үеийн сэтгэл гутрал гэдэг.<sup>1</sup> Дэлхийн олон оронд хийгдсэн тархалтын судалгааны үр дүнгээс хараад жирэмсэн үеийн сэтгэл гутралын тархалт 10-15 хувийн тархалттай бөгөөд жирэмсний сүүлийн саруудад илүүтэй тохиолддог байна.<sup>3-6</sup> Төрсний дараах сэтгэл гутралтай эмэгтэйчүүдийн 40-50%-д нь жирэмсэн үедээ эхэлсэн байдаг гэж үздэг.

Манай улсын судлаач Т.Мандхай нарын 2020 онд онлайн сууринж цахим орчиноор 600 жирэмсэн эхийг хамруулж хийсэн судалгаанд жирэмсэн эхчүүдийн сэтгэл гутралын тархалт 41.2% (N=247) байсан ба 34.3 % (N=206) нь амиа хорлох бодолтой байжээ.<sup>26</sup> Мөн 2002 онд Улаанбаатар хотын 1044 эмэгтэйг хамруулж хийсэн судалгаанд төрсний дараах сэтгэл гутралын тархалт нь 9.1% байсан бол 2017 онд Т.Мандхай нарын АНУ-ын Рочестрийн их сургуулийн дэмжлэгтэйгээр вэбэд суурилсан “lime survey” программаар цахим орчинд 480 эхчүүдээс өөрсдөөр нь асуумж бөглүүлж хийсэн судалгаагаар 31.5% (N=151)-д төрсний дараах сэтгэл гутрал илэрч байжээ.<sup>30</sup>

Манай улсад жирэмсэн болон төрсний дараах үеийн сэтгэл гутралын тархалтыг улсын хэмжээнд судалсан судалгааны ажил өнөөдрийг хүртэл ховор байгаа нь энэхүү судалгааг хийх үндэслэл болсон.

**Зорилго:** Жирэмсэн үеийн сэтгэл гутралын тархалтыг тогтоон, түүнд нөлөөлөх зарим эрсдэлт хүчин зүйлсийг илрүүлэх, шаардлагатай тусламж үйлчилгээг үзүүлж, төрсний дараах 3 дахь сард сэтгэл гутралыг дахин үнэлэх

**Судалгааны хэрэглэгдэхүүн, арга зүй:** Судалгааг агшингийн болон кохорт судалгааны загвараар чанар болон аналитик судалгааны аргуудыг ашиглан 2022 оны 02 сарын 21-ний өдрөөс 04 сарын 08-ны хооронд Улаанбаатар хотын 4 дүүрэг, Баруун, Зүүн, Хангай, Төвийн бүсийн нийт 11 аймаг, 12 сумын 80 түүврийн

нэгжээс санамсаргүй түүврийн аргаар судалгаанд оролцохыг зөвшөөрсөн 1482 жирэмсэн эхийг хамруулав. Баянзүрх болон Чингэлтэй дүүргийн судалгаанд оролцсон 468 жирэмсэн эхээс амаржсан 355 эхэд төрсний дараах сэтгэл гутралыг 11 сарын 15-наас 11 сарын 27-ны хооронд цахимаар/утсаар үнэлэв. Судалгаанд оролцогдоос нийт 4 бүлэг бүхий 79 асуумж, бие махбодын хэмжилт, сэтгэл гутралын эрсдэлтэй гарсан эмэгтэйчүүдэд сэтгэл гутралыг илрүүлэх, оношлох сэтгэцийн эмчийн эмнэл зүйн үзлэг хийв. Сэтгэл гутралыг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн 10 асуулт бүхий Эдинбургийн сорилоор үнэлж, нийт оноо 13-аас их үед сэтгэл гутралтай гэж үнэлсэн. Судалгааны мэдээллийг нэгтгэж, статистик боловсруулалтыг SPSS 24 програмыг ашиглан хийж гүйцэтгэв. Судалгааны ёс зүйг ЭМЯ-ны ёс зүйн хорооны 3 сарын 19-ний өдрийн хурлаар хэлэлцүүлж ёс зүйн зөвшөөрөл авсан (№267)

**Үр дүн:** Бидний судалгаанд Улаанбаатар хотын нийт 4 дүүрэг, хөдөө орон нутгийн 11 аймгийн 18-46 насны нийт 1482 жирэмсэн эх хамрагдсаны дундаж нас нь  $30.12 \pm 5.88$  байлаа. Судалгаанд хамрагдагсдын 21.8% (n=323) нь Улаанбаатар хотын Баянзүрх дүүргээс, 17.2% (n=255) нь Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргээс, 9.8% (n=145) Улаанбаатар хотын Чингэлтэй дүүргээс, 1.3% (n=20) нь Улаанбаатар хотын Багануур дүүргээс тус тус хамрагдсан бол Дундговь (2.4%, n=36), Хэнтий (2.9%, n=43), Говь-Алтай (3.2%, n=48) зэрэг аймгуудаас хамгийн цөөн эхчүүд хамрагдсан байна.

Бидний судалгаанд хамрагдагсдын 15.9% (n=235) нь сэтгэл гутралтай гэж оношлогдсон бол 84.1% (n=1247) нь сэтгэл гутралгүй байв. Жирэмсэн эхчүүдийн нас ( $r=-0.120$ ,  $p<0.001$ ) болон хувь хүний орлого ( $r=-0.056$ ,  $p=0.031$ ), төрөлтийн тоо ( $r=-0.065$ ,  $p=0.012$ ) зэрэг нь сэтгэл гутралыг үнэлэх асуумжийн оноотой урвуу сул хамааралтай байна. Өөрөөр хэлбэл жирэмсэн эхчүүдийн нас залуу байх, хувь хүний орлого буурах зэрэгт сэтгэл гутрал үүсэхэд шууд сул нөлөөлж байна. Сэтгэл гутралд хүргэж буй эрсдэлт хүчин зүйлсийг олон хүчин зүйлийн логистик регрессийн аргаар судалж үзэхэд нас, оршин сууж буй газар, жирэмсний хугацаа, жирэмслэлт төлөвлөсөн эсэх, гэр бүлийн болон одоогийн хүчирхийлэлд өртсөн эсэх зэрэг хүчин зүйлүүд жирэмсэн эхчүүдийг сэтгэл гутралаар өвдөхөд эрсдэлт хүчин зүйлс болох магадлалтай байна. Тухайлбал жирэмсэн эхийн нас залуу байх тусмаа сэтгэл гутралд өртөх эрсдэлтэй байна. Өөрөөр хэлбэл 40 болон түүнээс дээш настай эхчүүдтэй харьцуулахад 19 ба түүнээс доош насыхан 6.7 дахин ( $p=0.004$ ), 20-24 насыхан 4.7 дахин ( $p=0.001$ ), 25-29 насыхан 3.2 дахин ( $p=0.011$ ), 30-34 насыхан 3 дахин ( $p=0.012$ ) их сэтгэл гутралд өртөж байна.

Оршин суугаа харьяаллын хувьд хөдөө орон нутагт амьдарч буй жирэмсэн эхчүүд хотод амьдарч буй жирэмсэн эхчүүдээс 1.9 дахин ( $p=0.000$ ), жирэмсний сүүлийн 3 сартай жирэмсэн эхчүүдээс жирэмсний дунд 3 сартай эхчүүд 0.5 дахин ( $p=0.017$ ) илүү сэтгэл гутралд өртөх магадлалтай байна.

Жирэмслэлтийг төлөвлөсөн жирэмсэн эхчүүдийг төлөвлөөгүй эхчүүдтэй харьцуулахад 0.6 дахин ( $p=0.007$ ), одоогийн хүчирхийлэлд өртсөн жирэмсэн эхчүүдийг хүчирхийлэлд өртөөгүй эхчүүдтэй харьцуулахад 2.3 дахин ( $p=0.003$ ), сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн жирэмсэн эхчүүд өртөөгүйтэй харьцуулахад 0.3 дахин ( $p=0.002$ ), гэр бүлийн харилцааны хувьд тайван амгалан биш жирэмсэн эхчүүд тайван амгалан гэр бүлтэй эхчүүдээс 3.1 дахин ( $p=0.000$ ) их жирэмсний сэтгэл гутралд өртөх магадлалтай байна. Төрсний дараах сэтгэл гутралыг БЗД болон Чингэлтэй дүүрэгт өмнө нь судалгаанд хамрагдсан 468 эхээс амаржсан, судалгаанд оролцохыг зөвшөөрсөн 355 эхэд үнэлэхэд 20.3%( $n=72$ ) байв.

#### **Дүгнэлт:**

1. Монгол улсын Улаанбаатар хотын 4 дүүрэг, хөдөө орон нутгийн 11 аймгийн 12 сумын нийт 80 түүврийн нэгжээс 1482 жирэмсэн эхчүүдийн дунд сэтгэл гутралын тархалтыг судалж үзэхэд жирэмсэн үеийн сэтгэл гутрал 15.9 хувьтай байлаа.
2. Жирэмсэн эхчүүдийн нас хэт залуу байх, хөдөө орон нутагт амьдарч байх, төлөвлөөгүй жирэмслэлт, хүчирхийлэлтэй орчинд амьдрах, тэр дундаа сэтгэл санааны хүчирхийлэл, гэр бүлийн харилцаа тайван амгалан биш байх зэрэг нь жирэмсний үеийн сэтгэл гутрал үүсэхэд нөлөөлөх эрсдэлт хүчин зүйл болох магадлал өндөр байна.
3. Амаржсан эмэгтэйд төрсний дараах сэтгэл гутрал 20.3% байв.

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. УДИРТГАЛ

**Үндэслэл:** Дэлхий нийтэд бүх насны 350 саяас илүү хүн сэтгэл гутралаар өвдөж байдаг ба эмэгтэйчүүд эрчүүдээс илүү сэтгэл гутралаар өвддөг.<sup>1, 2</sup> ДЭМБ-ын мэдээгээр сэтгэл гутрал нь 2020 оны нийт өвчлөлийн дотор хоёрдугаарт жагсаж байгаа<sup>3</sup> нь уг эмгэгийг зонхилон тохиолдох сэтгэцийн эмгэгийн нэг болохыг батлаад зогсохгүй хөгжиж байгаа улс орнуудын нийгмийн эрүүл мэндийн хамгийн тулгамдсан асуудлын нэг болж байна.

Сэтгэл гутрал нь зонхилон тохиолдох сэтгэцийн эмгэгийн нэг бөгөөд хөгжиж байгаа улс орнуудын нийгмийн эрүүл мэндийн хамгийн тулгамдсан асуудлын нэг болдог.<sup>4</sup> Судалгаануудаас харахад сэтгэл гутрал болон эм бодисын хамааралтай донтолт нь нийт хүн амын дунд түгээмэл тохиолддог ба хөдөлмөрийн чадвар алдалтыг бий болгон, эмчлэгдэхгүй бол архаг байдалд шилжиж, цаашдаа өвчлөл үхлийг нэмэгдүүлдэг нь судалгаануудаар батлагдсаар байна.<sup>4-5</sup> Жирэмсэн эмэгтэйчүүдийн сэтгэл гутрах эмгэг нь ихэвчлэн оношлогддоггүй, тусlamж үйлчилгээ авч чаддаггүйгээс болж хоолноос татгалзах, дургүй байх зэрэгтэй холбоотойгоор хоол тэжээлийн дутагдалд орох, ураг жин багатай төрөх, ургийн өсөлт бага байх зэрэг олон сөрөг эрсдэлийг бий болгодог. Жирэмсэн эмэгтэйчүүд нь сэтгэл гутралыг жирэмсэн үедээ мэдэхгүй, анзаарахгүйгээс ихэвчлэн оношлогддоггүй, тусlamж үйлчилгээ авч чаддаггүй байна.<sup>31-33</sup>

Жирэмсэн эхчүүдэд өдрийн ихэнх цагт уйтгарлан гуних, итгэл найдвараа алдах, аливаа зүйлд сонирхолгүй болж, ядарч сульдах, нойрмоглох, хооплох байдал өөрчлөгдөн, уурлаж уцаарлах, аз жаргалыг мэдэрч чадахгүй байх зэрэг шинжүүдээр илэрдэг эмгэгийг жирэмсэн үеийн сэтгэл гутрал гэнэ.<sup>6</sup>

Дэлхийн олон оронд хийгдсэн тархалтын судалгааны үр дүнгээс харахад жирэмсэн үеийн сэтгэл гутралын тархалт 10-15 хувийн тархалттай ба жирэмсний сүүлийн саруудад илүүтэй тохиолддог байна.<sup>13-16</sup> Төрсний дараах сэтгэл гутралтай эмэгтэйчүүдийн 40-50% нь жирэмсэн үедээ сэтгэл гутрал нь эхэлсэн байdag ажээ.

Манай улсын судлаач Т.Мандхай нарын 2020 онд цахим орчиноор 600 жирэмсэн эхээс сэтгэл гутралын тархалтыг үнэлэх судалгааг хийхэд 41.2% (N=247) нь сэтгэл гутралтай, 34.3 % (N=206) нь амиа хорлох бодолтой байжээ.<sup>26</sup> 2002 онд Улаанбаатар хотын 1044 эмэгтэйчүүдийг хамруулж хийсэн судалгаанд төрсний дараах сэтгэл гутралын тархалт 9.1% байсан бол 2017 онд Т.Мандхай нарын АНУ-ын Рочестрийн их сургуулийн дэмжлэгтэйгээр вэбэд суурилж цахим орчиноор 480 эхчүүдээс өөрсдөөр нь асуумж бөглүүлэх аргаар хийсэн судалгаагаар 31.5% (N=151)-д төрсний дараах сэтгэл гутрал илэрч байжээ.<sup>26</sup>

Гэтэл манай улсад жирэмсэн болон төрсний дараах үеийн сэтгэл гутрал, сэтгэл түгшилтийн тархалтыг улсын хэмжээнд судалсан судалгааны ажил чөнөөдрийг хүртэл хомс байгаа нь энэхүү судалгааг хийх үндэслэл болсон.

**Судалгааны ажлын зорилго:** Жирэмсэн үеийн сэтгэл гутралын тархалтыг тогтоон, түүнд нөлөөлөх зарим эрсдэлт хүчин зүйлсийг илрүүлэх, шаардлагатай тусlamж үйлчилгээг үзүүлж, төрсний дараах З дахь сард сэтгэл гутралыг сонгогдсон дүүрэгт ахин үнэлэх

#### **Судалгааны ажлын зорилт:**

1. Жирэмсэн үеийн сэтгэл гутралын тархалтыг тогтоох
2. Жирэмсэн үеийн сэтгэл гутралд нөлөөлөх зарим эрсдэлт хүчин зүйлсийг илрүүлэн, шаардлагатай тусlamж үйлчилгээг үзүүлэх
3. Төрсний дараах З дахь сард Улаанбаатар хотын Чингэлтэй, Баянзүрх дүүргийн эмэгтэйчүүдийн сэтгэл гутралыг цахим сүлжээгээр болон утсаар ахин үнэлэх

#### **Судалгааны ажлын практик ач холбогдол**

Жирэмсэн үеийн сэтгэл гутралын тархалтыг улсын хэмжээнд тогтоож, нөлөөлж буй зарим эрсдэлт хүчин зүйлсийг судласнаар жирэмсэн үеийн тусlamж үйлчилгээнд сэтгэцийн эрүүл мэндийн дэмжлэг тусlamжийн хэрэгцээг тодорхойлох суурь судалгаа болно.

#### **Судалгааны ажлын шинэлэг тал**

Манай улсад жирэмсэн үеийн сэтгэл гутралын тархалтыг улсын хэмжээнд анх удаа тогтоож, нөлөөлж буй зарим эрсдэлт хүчин зүйлсийг судлахаас гадна жирэмсний болон төрсний дараах сэтгэл гутралыг илрүүлэхэд олон улсад түгээмэл хэрэглэдэг стандарт асуумжийг өөрийн орны онцлогт тохирч байгаа эсэхийг үнэлэх нь бидний судалгааны ажлын шинэлэг тал юм.

#### **Судалгааны таамаглал**

1. Жирэмсэн үеийн сэтгэл гутралын тархалт 15-25 орчим хувийн тархалтай байна.
2. Жирэмсэн үеийн сэтгэл гутралд төрөлт болон жирэмсний хүндрэл, төлөвлөөгүй болон хүсээгүй жирэмслэлт, ээж ганц бие байх, ажилгүй байх, гэр бүлийн хүчирхийлэлд өртдөг, ойр дотно хүмүүсийн дэмжлэг туслалцаа дутмаг байх, өрхийн санхүүгийн хүрэлцээгүй байдал, гэр бүлийн болон харилцааны зөрчилтэй байх, эцэг эх, хадам эцэг эхтэйгээ харилцаа муу байх зэрэг нь нөлөөлөх эрсдэлт хүчин зүйлс болно.
3. Төрсний дараах сэтгэл гутрал нь жирэмсний үеийн сэтгэл гутралгүй эрүүл ээжүүдэд харьцангуй бага хувьтай илэрнэ. Харин жирэмсэн үедээ сэтгэл гутралтай байсан ээжүүдийн 50 орчим хувь нь төрсний дараах сэтгэл гутрал үргэлжилж илэрнэ-

### **Судалгааны ажлын ёс зүй**

1. АШУҮИС-ийн Анаагаах Ухааны Ёс Зүйн Салбар Хорооны 2022 оны 02 сарын 18-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж судалгаа явуулах ёс зүйн зөвшөөрөл авсан. Мөн Эрүүл мэндийн яамны Ёс зүйн хорооны 2022 оны 03 сарын 15-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж ёс зүйн зөвшөөрөл давхар авсан. (ЭМЯ, анаагаах ухааны ёс зүйн хяналтын хорооны тогтоол № 267)
2. Судалгаанд оролцогч бүрээс таниулсан зөвшөөрлийн хуудсын дагуу судалгааны ажлын зорилго, ёс зүйн асуудлыг танилцуулан судалгаанд сайн дураар оролцох эсэх талаар зөвшөөрөл авсан. Судалгаанд оролцогч өөрөө зөвшөөрсөн тохиолдолд оролцогчоор гарын үсэг зуруулж баталгаажуулсан.
3. Судалгааны ажлыг дууссаны дараа ёс зүйн зөрчил гаргасан эсэх талаар ЭМЯ-ны Ёс зүйн хорооны хурлаар хэлэлцүүлнэ.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ. ХЭВЛЭЛИЙН ТОЙМ

Дэлхий нийтэд бүх насын 350 саяас илүү хүн сэтгэл гутралаар өвдөж байдаг ба эмэгтэйчүүд эрчүүдээс илүү сэтгэл гутралаар өвддөг.<sup>1, 2</sup> ДЭМБ-ын мэдээгээр сэтгэл гутрал нь 2020 оны нийт өвчлөлийн дотор хоёрдугаарт жагсаж байна.<sup>3</sup> Сэтгэл гутрал нь зонхилон тохиолдох сэтгэцийн эмгэгийн нэг бөгөөд хөгжиж байгаа улс орнуудын нийгмийн эруул мэндийн хамгийн тулгамдсан асуудлын нэг болдог. Судалгаануудаас харахад сэтгэл гутрал болон эм бодисын хамааралтай донтолт нь нийт хүн амын дунд түгээмэл тохиолддог ба хөдөлмөрийн чадвар алдалтыг бий болгон, эмчлэгдэхгүй бол архаг байдалд шилжиж, цаашдаа өвчлөл үхлийг нэмэгдүүлдэг нь судалгаануудаар батлагдсаар байна.<sup>4, 5.</sup>

Жирэмсэн эхчүүд өдрийн ихэнх цагт уйтгарлан гуних, итгэл найдвараа алдах, аливаа зүйлд сонирхолгүй болж, ядарч сульдах, нойрмоглох, хоолпох байдал өөрчлөгдөн, уурлаж уцаарлах, аз жаргалыг мэдэрч чадахгүй байх зэрэг шинжүүдээр илэрдэг эмгэгийг жирэмсэн үеийн сэтгэл гутрал гэнэ.<sup>6</sup> Жирэмсний сэтгэл гутралын үед биеийн болон сэтгэл зүйн маш олон шинжүүд гарч ирдэг. Тухайлбал ядарч сульдах, уйлах, баяр баясгалангүй болох, түгших, бодол санаа төвлөрөхгүй байх, хоолны дур өөрчлөгдөх, нойрны өөрчлөлтүүд гарах, юманд идэвхи сонирхол буурах, өдөр тутмын үйл ажиллагаагаа хийж чадахгүй болох, амиа хорлох зэрэг олон шинжүүд гарч ирж болно.<sup>7, 8</sup>

ДЭМБ, НҮБ-ын хүн амын сангийн хамтарсан судалгаануудаас үзэхэд төрсний дараах сэтгэл гутрал нь өндөр хөгжилтэй орнуудад хүн амын 10-15%, хөгжиж буй орнуудад 10-41%-ийн тархалттай байдаг ба эдийн засгийн хувьд бага, дунд орлоготой улс орнуудад ялгаатай байдаг гэж мэдээлжээ.<sup>9-12</sup> Дэлхийн олон оронд хийгдсэн тархалтын судалгааны үр дүнгээс харахад жирэмсэн үеийн сэтгэл гутралын тархалт дунджаар 10-15 хувийг, зарим судалгаануудад ялгаатай үр дүн гарчээ. Дэлхийн олон оронд хийгдсэн судалгаануудад жирэмсний сэтгэл гутралын тархалт бага нь 4%, өндөр нь 81% хүртэл ялгаатай үр дүн гарсан байна.<sup>13-16</sup> Энэ судалгаа нь АНУ-д олон жилийн турш хийгдсэн судалгааны дундаж 16%-ийн тархалттай,<sup>17</sup> Саудын Арабад 31,9%,<sup>18</sup> Пакистанд 42,7%,<sup>19</sup> олон судалгааг харьцуулсан метаанализ тойм судалгаагаар 15-65%-ийн тархалттай гэсэн судалгаануудтай<sup>20</sup> адил үр дүнгүүд гарсан байна. Мөн жирэмсний сэтгэл гутралын тархалт нь өндөр орлоготой Австралид 7%, Хонгконгод 4,4%, Финляндад 7,7% байсан бол бага орлоготой Пакистанд 64,6%, Бангладешэд 18%, Нигерид 24,5%, Этиопид 24,94% зэрэг улс орнуудад их байсан байна. Энэтхэгийн Мумбай хотод 9.18%, Энэтхэгийн Бенгалур хотод 12,13%,<sup>21,22</sup> Энэтхэгийн Бангалор хотод 35,7%, Бразилийн Рио де Жанеро хотод 14.2%,<sup>23</sup> Өмнөд Африкийн Квазули-Наталд 15,9%,<sup>24</sup> Этиопын Апар мужийн Дабти эмнэлгийн судалгаагаар 17,9%, Этиопын Амхара мужийн Анеда воредагийн судалгаагаар 15,2%<sup>25</sup>-ийн тархалттай байсан бөгөөд жирэмсний сүүлийн саруудад илүүтэй тохиолддог гэжээ.<sup>3-6</sup> Зарим судалгаануудад жирэмсний сэтгэл

гутралын тархалтыг дундажаар 25-30% байдаг ба 20% нь хүнд сэтгэл гутрал гэж оношлогдог гэсэн.<sup>7,8</sup>

Мөн 2011 онд судлаач Roomruangwong нар нь 1968-2010 оны судалгаануудад метаанализ тойм судалгаа хийхэд Азийн орнуудад жирэмсний сэтгэл гутралын тархалт 20%, 2016 онд Gelaye нар нь 1998-2015 онуудад хийгдсэн судалгаануудад метаанализ тойм судалгаа хийхэд бага дунд орлоготой улс орнуудад жирэмсний сэтгэл гутралын тархалт 25,3% гэж судлагджээ.<sup>20</sup>

Харин манай улсад судлаач Т.Мандхай нар нь жирэмсэн үеийн сэтгэл гутралын тархалтыг илрүүлж, түүнд нөлөөлөх эрсдэлт хүчин зүйлсийг судлан тогтоох судалгаа хийсэн. Судалгааны ажлыг 2020 оны 10 сард 3 долоо хоногийн хугацаанд гүйцэтгэж, нэг агшигийн загвараар явуулсан. Судалгаанд Улаанбаатар хот, хөдөө орон нутаг, гадаад улсад амьдарч буй 600 жирэмсэн эхчүүдийг хамруулсан. Тусгайлан боловсруулсан асуумжаа вэбэд суурилсан “Google Survey” программ ашиглан оруулж, хамгийн өргөн хэрэглэдэг нийгмийн цахим орчин болох фейсбүүк, твиттер хуудсанд байршуулж судалгааны мэдээллийг цуглувансан. Нийт судалгаанд оролцсон 600 жирэмсэн эхийг насын хувьд авч үзвэл 15-19 насыхан 35 (5.8%), 20-29 насыхан 394 (65.6%), 30-39 насыхан 161 (26.8%), 40-49 насыхан 10 (1.6%) байв.<sup>26</sup> Судалгаанд оролцсон нийт жирэмсэн эхчүүдийн сэтгэл гутралын тархалт 247 (41.2%) байсан ба 206 (34.3 %) нь амиа хорлох бодолтой байлаа. Дээд боловсролтой, гэр бүлтэй, 1 сая хүртэлх төгрөгийн өрхийн орлоготой жирэмсэн эхчүүдийн дунд амиа хорлох бодол бүхий сэтгэл гутрал илэрч байгаа нь статистик ач холбогдолтой ( $p<0.001$ ) байсан бол жирэмслэлтээ урьдчилж төлөвлөөгүй байх нь эхчүүдийг сэтгэл гутралаар өвчлөхөд томоохон эрсдэлт хүчин зүйл болохын зэрэгцээ жирэмсний сүүлийн саруудад амиа хорлох бодолтой байх нь статистикийн хувьд ач холбогдолтой ( $p<0.001$ ) байсан.<sup>26</sup>

Харин хөгжиж байгаа улс орнуудад 3-5 жирэмсэн эмэгтэй тутмын 1 нь жирэмсэн болон төрсний дараах үеийн мэдэгдэхүйц сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай байдаг болохыг<sup>27,28</sup> Африkad жирэмсэн болон төрсний дараах үед хийсэн олон судалгаанууд батлаж байна.<sup>29</sup> Мөн биеийн жингийн илүүдэл, таргалалт нь нь жирэмсний сэтгэл гутралтай холбоотой гэж зарим судалгаануудад мэдээлжээ. Судлаач B.Sheeba нарын Энэтхэгийн Бангалор хотод 2019 онд 280 жирэмсэн эмэгтэйд хийсэн судалгаагаар хамааралгүй гэж судлагджээ.<sup>16</sup>

Судлаач Monica Maria нар нь жирэмсний сэтгэл гутрал, түүнд нөлөөлөх эрсдэлт хүчин зүйлийг судлах судалгааг хийсэн. 2013 онд Бразилийн Алфена хотод 209 жирэмсэн эмэгтэйд хийсэн судалгаагаар жирэмсний сэтгэл гутрал 14,8%-тай тогтоогдсон бөгөөд жирэмсний хугацаатай харьцуулан үзэхэд сэтгэл гутралтай эмэгтэйчүүдийн 48,4% нь хоёр дахь 3 сардаа байгаа хэдий ч, статистикаар үнэн магадтай нь батлагдаагүй байна.<sup>15</sup> Дэлхийн олон орнуудад хийгдсэн судалгаануудыг нэгтгэж хийсэн метаанализ судалгааны үр дүнгээс

харвал төрсний дараах сэтгэл гутрал нь БНХАУ-д 28.5%, Танзани улсад 39.5%, Бразил улсад 20.2%-ийн тус тус тархалттай байна.<sup>11-12</sup>

Манай улсад төрсний дараах сэтгэл гутралын тархалтыг 2002 онд Улаанбаатар хотын 1044 эмэгтэйд хийсэн судалгаанд 9.1% байсан бол 2017 онд судлаач Т.Мандхай нарын цахим орчиныг ашиглаж 480 эхчүүдээс авсан асуумж судалгаагаар 31.5% (N=151)-д төрсний дараах сэтгэл гутрал илэрсэн байна. Гэрлэлтийн байдал, ажил эрхлэлт, хүсээгүй жирэмслэлт, төрөх үеийн болон жирэмсний хүндрэлүүд, төрсний дараах сэтгэл гутрал, түгшүүрийг үүсгэдэг гэжээ. Судалгааны асуумжаа интернетэд суурилсан “lime survey” –өөр суурин болон зөөврийн компьютер, ухаалаг утас, ухаалаг дэлгэц зэргээр бөглүүлж авсан байна.<sup>30</sup>

Жирэмсэн эмэгтэйчүүдийн сэтгэл гутрах эмгэг нь ихэвчлэн оношлогддоггүй, тусламж үйлчилгээ авч чаддаггүйгээс болж хоолноос татгалзах, дургүй байх зэрэгтэй холбоотойгоор хоол тэжээлийн дутагдалд орох, ураг жин багатай төрөх, ургийн өсөлт бага байх зэрэг олон сөрөг эрсдэлийг бий болгодог. Жирэмсэн эмэгтэйчүүд нь сэтгэл гутралыг жирэмсэн үедээ мэдэхгүй, анзаарахгүйгээс ихэвчлэн оношлогддоггүй, тусламж үйлчилгээ авч чаддаггүй байна.<sup>31-33</sup> Хэвлэлийн тоймоос хараад төрсний дараах сэтгэл гутралтай эмэгтэйчүүдийн 40-50%-д нь жирэмсэн үедээ уг эмгэг нь эхэлсэн байдаг ба өмнөх жирэмслэлт бүтэлгүй болох, өсвөр үеийн жирэмслэлт, төрөлт болон жирэмсний хүндрэл, төлөвлөөгүй болон хүсээгүй жирэмслэлт, ганц бие байх, боловсрол багатай, ажилгүй байх, хүүхэд төрүүлэх айдастай байх, төрөлхийн эмгэгтэй хүүхэд төрүүлэх, нөхрийн (хамтран амьдрагчийн) хүчирхийлэлд өртдөг, хэн нэгний туслалцаа дэмжлэг дутмаг байх, нөхрийн зүгээс сэтгэл санаа эдийн засгийн дэмжлэг дутмаг байх, өрхийн санхүүгийн хүрэлцээгүй байдал, гэр бүлийн болон харилцааны зөрчилтэй байх, эцэг эх, хадам эцэг эхтэйгээ харилцаа муу байх, жирэмсэн болохоосоо өмнө сэтгэцийн тулгамдсан асуудлаар өмнэлэгт хандаж байсан зэрэг нь жирэмсэн үеийн болон төрсний дараах сэтгэл гутралаар өвчлөх эрсдэлт хүчин зүйл болохыг мэдээлжээ.<sup>34,35-38</sup>

Жирэмсэн үедээ сэтгэл гутралд өртөх нь эх, урагт адилхан сөргөөр нөлөөлдөг байна.<sup>39</sup> Тухайлбал жирэмсэн эмэгтэй сэтгэл гутралаар шаналах нь ураг зулбах, цагаасаа өмнө төрөх, хожуу үеийн хордлогод өртөх, ургийн өсөлтийн саатал зэрэг эрсдэлийг нэмэгдүүлдэг бол ирээдүйд мэндлэх хүүхэд жин багатай төрөх, ээжтэйгээ ээнэгшил үүсэхэд бэрхшээлтэй байх, хүүхдийн хүчирхийлэл болон үл хайхрах байдалд өртөх, анхаарал дутмагшил хэт хөдөлгөөнтөх эмгэг, импульсив эмгэг, хэл ярианы бэрхшээл, төрх үйлийн эмгэг зэргээр өвчлөх эрсдэлтэй болохыг судлаачид тогтоожээ.<sup>40-42</sup>

Хэрэв жирэмсэн үеийн сэтгэл гутралыг эмчлэхгүй бол даамжирч төрсний дараах сэтгэл гутралаар өвчлөх эрсдэлийг нэмэгдүүлдэг гэж үздэг байна. Иймээс жирэмсэн үеийн сэтгэл гутралыг эрт илрүүлж, цаг алдалгүй тусламж үйлчилгээ

үзүүлэх нь эх, хүүхдийн бие болоод сэтгэцийн эрүүл мэндэд чухал ач холбогдолтой юм.<sup>43</sup>

Эхчүүд жирэмсэн болохоос өмнө сэтгэцийн тулгамdsан асуудалтай байсан боловч тэдний дийлэнх нь мэргэжлийн байгууллагын тусlamж үйлчилгээ авч чадахгүй байгаа нь жирэмсэн үед сэтгэл гутралаар өвчлөх эрсдэлийг улам бүр нэмэгдүүлж байна. Мөн жирэмсэн үеийн сэтгэл гутралын шинжүүд нь бие махбодын бусад зовууриудад дарагдаж, эмч нар ихэнхдээ биеийн зовуурьт гол анхаарлаа хандуулдаг учир оношлоход төвөгтэй ажээ.<sup>43</sup> Жирэмсэн эхчүүдийн хяналтын үзлэгт сэтгэл гутралыг илрүүлэх сорилыг нэвтрүүлэх нь эрт оношилж, тусlamж үйлчилгээг цаг алдалгүй үзүүлэхэд хэрэгтэй байдаг байна.<sup>43</sup> Энэ нь эмэгтэйчүүдийн сэтгэцийн эрүүл мэнд, бие махбодь, гэр бүлийн хэвийн амьдрал, үр хүүхэд зэрэг олон хүмүүст өвчин эмгэгийг үүсгэдэг.<sup>44-46</sup> Жирэмсний сэтгэл гутралын шинж тэмдэг нь эрүүл мэндийн салбарын тусlamж үйлчилгээнд сөргөөр нөлөөлж, төрөх тойрны эмгэг, жирэмсний хүндрэл, эхийн нас бараптыг хүртэл нэмэгдүүлэх хүчин зүйл болдог байна.<sup>47-48</sup> Тиймээс АНУ-ын Эх барих, эмэгтэйчүүдийн их сургууль нь эмч нарыг жирэмсэн эхчүүдээс жирэмсний хугацаанд ядаж 1 удаа сэтгэл гутралын сорил авахыг зөвлөсөн байна.<sup>49</sup>

Жирэмсний сэтгэл гутралыг эмчлэхгүй байх нь жирэмсэн болон төрөх үеийн хүндрэл, эхийн манас таталт эклампси, хүүхэд бага жинтэй төрөх, хүүхдийн уураг тархины хөгжил, хугацаанаас өмнө төрөх, кесеро хагалгаагаар төрөх, апгарын оноо бага байх зэргийг нөхцөлдүүлсэнээр төрсний дараах сэтгэл гутрал үүсэх эрсдэлт хүчин зүйл болдог байна.<sup>50-52</sup>

Жирэмсний сэтгэл гутрал нь хөгжиж байгаа оронд нийгмийн эрүүл мэндийн тулгамdsан асуудал болсон төдийгүй эх, нярай, хүүхдийн эрүүл мэндэд бүгдэд нь сөргөөр нөлөөлдөг байна.<sup>53</sup> Манай улсад жирэмсэн болон төрсний дараах үеийн сэтгэл гутралын тархалтыг улсын хэмжээнд судалсан судалгааны ажил ч өнөөдрийг хүртэл хомс байна. Иймээс жирэмсэн үеийн сэтгэл гутралын тархалтыг улсын хэмжээнд тогтоон, зарим эрсдэлт хүчин зүйлийг илрүүлэх, цаашид жирэмсэн болон төрсөн ээжүүдэд үзүүлэх сэтгэцийн эрүүл мэндийн тусlamж үйлчилгээг хөгжүүлэх шаардлага бидний өмнө тулгарч байгаа нь уг судалгаа хийх үндэслэл болж байна.

Жирэмсэн үеийн сэтгэл гутрал бол нийгмийн эрүүл мэндийн хамгийн чухал тулгамсан асуудал бөгөөд эх хүүхдийн эрүүл мэндэд хоёуланд нь сөрөг нөлөө, үр дагаврыг өгдөг. Энэ асуудал нь хөгжингүй болон хөгжиж байгаа улс орнуудад аль алиных нь өвчлөлд нөлөөгөө үзүүлж байдаг. Хэдий тийм байгаа ч энэ нь илрүүлэлт багатай, анхааралд орохгүй хоцроод байгаа нь судалгааны үр дүнгээр нотлогддог. Судлаач Yonas Tesfaya 2019 онд хийсэн жирэмсний сэтгэл гутралын тархалт, эрсдэлт хүчин зүйлийг тогтоох судалгааг Этиопын Жими тосгоны Кошигийн эрүүл мэндийн төвд хийсэн.<sup>54</sup> Эрүүл мэндийн төвд суурилан 2019 оны 02 сарын 15-наас 04 сарын 15-ны дотор Кошигийн эрүүл мэндийн төвд үйлчилгээ

авсан 314 жирэмсэн эмэгтэйд судалгаагаа хийсэн. Дата мэдээллээ цуглуулахдаа урьдчилсан судалгаа явуулж, нүүр тулсан ярилцлага, бэлдсэн асуумжинд хариулах, сэтгэцийн эмнэл зүйн үзлэг хийсэн.<sup>54</sup> Судлаач Юunas Теспаяагийн Этиопийн Жимми хотын Кошигийн эрүүл мэндийн төвд хийсэн судалгаанд нийт 1483 жирэмсэн эмэгтэй судалгаанд хамрагдсанаас жирэмсний сэтгэл гутралын тархалт 52 (16.6%) байв. Жирэмсний сэтгэл гутралд эрсдэлт хүчин зүйлийг тогтооход гэр бүлийн байдал, өмнө нь сэтгэл гутралаар өвдөж байсан байдал, жирэмсний төлөвлөлт,abortын түүх, нийгмийн дэмжлэг, гэр бүлийн хүчирхийлэл хамааралтай байв. Жирэмсний сэтгэл гутралын тархалт өндөр байдаг ба нийгэм сэтгэл зүй, эмнэл зүй, эх барих эмэгтэйчүүдийн олон хүчин зүйл хамааралтай байдаг байна. Түүнчлэн жирэмсний сэтгэл гутралыг эрт илрүүлэх, сэтгэцийн эрүүл мэндийн тусlamж үйлчилгээг үзүүлэх нь эх болон хүүхдэд дараа нь үүсэх сөрөг үр дагавраас сэргийлэх ач холбогдолтой. Жирэмсэн эмэгтэйчүүд ихэвчлэн оношлогддоггүй, тусlamж үйлчилгээ авч чаддаггүйгээс хоолонд дургүй байснаас хоол тэжээлийн дутагдалд орох, урагжин багатай төрөх, ургийн өсөлт бага байх зэрэг олон эрсдэлийг бий болгодог.<sup>54</sup> Жирэмсэн эмэгтэйчүүд үүнийгээ жирэмсэн үедээ мэдэхгүй, анзаarahгүйгээс ихэвчлэн оношлогддоггүй, тусlamж үйлчилгээ авч чаддаггүй байна.<sup>31-33</sup>

Жирэмсний сэтгэл гутралын үед биеийн болон сэтгэл зүйн маш олон шинжүүд гарч ирдэг. Тухайлбал ядарч сульдах, уйлах, баяр баясгалангүй болох, түгших, бодол санаа төвлөрөхгүй байх, хоолны дур өөрчлөгдөх, нойрны өөрчлөлтүүд гарах, юманд идэвхи сонирхол буурах, өдөр тутмын үйл ажиллагаагаа хийж чадахгүй болох, амиа хорлох зэрэг олон шинжүүд гарч ирж болно. Жирэмсний сэтгэл гутралын тархалт дундажаар 25-30% тохиолддог ба 20% нь хүнд сэтгэл гутрал гэж оношлогдохоор байдаг.<sup>7-8</sup> Энэ нь эмэгтэйчүүдийн сэтгэцийн эрүүл мэнд, бие махбодь, гэр бүлийн хэвийн амьдрал, үр хүүхэд зэрэг олон хүмүүст өвчин эмгэгийг үүсгэдэг.<sup>44-46</sup>

Жирэмсний сэтгэл гутралын шинж тэмдэг нь эрүүл мэндийн салбарын тусlamж үйлчилгээнд сөргөөр нөлөөлж, төрөх тойрны эмгэг, жирэмсний хүндрэл, эхийн нас баралтыг хүртэл нэмэгдүүлэх хүчин зүйл болдог.<sup>47-48</sup> Жирэмсний сэтгэл гутрал нь хөгжиж байгаа оронд нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал болсон төдийгүй эх, нярай, хүүхдийн эрүүл мэндэд бүгдэд нь сөргөөр нөлөөлдөг байна.<sup>53</sup> Хөгжиж байгаа улс орнуудад 3-5 жирэмсэн эмэгтэй тутмын 1-д нь жирэмсэн болон төрсний дараах үеийн мэдэгдэхүйц сэтгэцийн эрүүл мэндийн асуудал байдаг байна.<sup>27-28</sup> Энэ талаар жирэмсэн болон төрсний дараах үед хийсэн олон судалгаанууд батлаж байдаг.

Үндэсний болон олон улсын байгууллагууд эхийн сэтгэцийн эрүүл мэндэд анхаарал хандуулж байгаа хэдий ч жирэмсний үеийн сэтгэл гутрал нь эрүүл мэндийн тогтолцоонд үл тоомсорлодог асуудал хэвээр байгаа бөгөөд судалгаанд ч бага ач холбогдол өгдөг. Түүгээр ч барахгүй жирэмсний үеийн сэтгэл гутралын талаар нотлох баримт хомс байдаг. Үнэн хэрэгтээ сэтгэцийн

эрүүл мэндийн тусламж үйлчилгээг илүү чухалчилж, зохих арга хэмжээг төлөвлөхөд илүү сайн нотолгоо хэрэгтэй байна. Нэмж дурдахад энэхүү судалгааны үр дүн нь цаашдын судалгааны үндэс суурь болох юм.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ ХЭРЭГЛЭГДЭХҮҮН БА АРГА ЗҮЙ

### 3.1 Судалгааны загвар

Судалгааг Монгол улсын нийт нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдэд суурилан нэг агшингийн болон коорт судалгааны загваруудыг ашиглаж аналитик болон чанарын судалгааны аргыг ашиглан хийсэн. Үүнд:

- Агшингийн судалгаа: Жирэмсэн үеийн сэтгэл гутрал түүнд нөлөөлөх зарим эрсдэлт хүчин зүйлсийг 2022 оны 02 дугаар сарын 21–нээс 04 сарын 08–ны хооронд хийсэн.
- Коорт судалгаа: Төрсний дараах үеийн сэтгэл гутралыг Баянзүрх болон Чингэлтэй дүүргийн судалгаанд хамрагдсан нийт 468 жирэмсэн эхээс амаржсан, судалгаанд оролцохыг зөвшөөрсөн 355 эхийн төрсний дараах сэтгэл гутралыг дахин үнэлсэн.

### 3.2 Судалгааны хамрах хүрээ

- Жирэмсэн үеийн сэтгэл гутралын тархалт, түүнд нөлөөлж буй эрсдэлт хүчин зүйлийн судалгааг Улаанбаатар хотын 4 дүүрэг (Сонгинохайрхан, Чингэлтэй, Баянзүрх, Багануур), Баруун (Ховд, Говь-Алтай, Завхан), Төв (Өмнөговь, Төв, Дундговь), Хангай (Архангай, Өвөрхангай, Баянхонгор), Зүүн (Дорнод, Хэнтий) бүсийн нийт 11 аймаг, 12 сумын нийт 80 түүврийн нэгжийн жирэмсний хяналтанд хянагдаж буй 6-40 долоо хоногтой жирэмсэн эхчүүдээс санамсаргүй түүврийн аргаар 1482 судалгаанд оролцохыг өөрөө зөвшөөрсөн жирэмсэн эхчүүдийг хамруулсан.
- Төрсний дараах сэтгэл гутралыг Улаанбаатар хотын Баянзүрх, Чингэлтэй дүүргийн судалгаанд хамрагдсан 468 эхээс судалгаанд хамрагдахыг зөвшөөрсөн 355 эхийг хамруулав.

### Зураг 1. Судалгаанд оролцогчдыг сонгож хамруулсан үйл явцын зураглал



### **3.3 Судалгаанд оролцогчдыг хамруулах болон хасах шалгуур**

Судалгаанд хамруулах шалгуур	Судалгаанаас хасах шалгуур
<ul style="list-style-type: none"><li>• 18-аас дээш настай, Монгол улсын иргэн байх</li><li>• Таниулсан зөвшөөрөлтэй танилцаж судалгаанд оролцохыг албан ёсоор зөвшөөрсөн</li><li>• Нэг урагтай жирэмсэн</li></ul>	<ul style="list-style-type: none"><li>• Судалгаанд оролцохоос татгалзсан</li><li>• Ихэр урагтай жирэмсэн</li></ul>

### **3.4 Судалгааны хэрэглэгдэхүүн ба мэдээлэл цуглуулсан арга**

Судалгааны мэдээлэл авахдаа асуумж бөглүүлэхээс гадна сэтгэцийн эмч эмнэлзүйн ганцаарчилсан ярилцлага хийж, сэтгэцийн болон бие махбодын үзлэг, хэмжилт хийж, мэдээ материалуудаа цуглуулсан.

**Нэгдүгээрт:** Эмнэлзүйн ганцаарчилсан ярилцлага хийж асуумжийн аргаар уг судалгаанд орох таниулсан зөвшөөрлийн хуудсыг танилцуулж, тусгайлан боловсруулсан судалгааны асуумжийг ашиглаж мэдээллээ цуглуулсан. Уг судалгааны асуумж нь дараах асуултуудтай байсан.(Хавсралт № 2)

1. Хүн ам зүйн өрөнхий мэдээлэл болох нас, гэрлэлтийн байдал, ам бүл, санхүүгийн байдал, боловсролын түвшин зэргийн талаар – 20 асуулт
2. Одоогийн болон өмнөх жирэмслэлт төрөлттэй холбоотой – 36 асуулт
3. Хорт зуршилыг үнэлэх – 13 асуулт
4. Жирэмсэн болон төрсний дараах сэтгэл гутралыг үнэлэх 10 асуулт бүхий олон улсад түгээмэл хэрэглэгддэг Эдинбургийн асуумж, нийт 79 асуултыг ашигласан.
5. Түүнчлэн судалгаанд оролцогдоос сэтгэцийн эмч олон улсад хэрэглэдэг MINI INTERNATIONAL NEUROPSYCHIATRIC INTERVIEW (M.I.N.I) нэртэй оношилгооны аргачлалын дагуу эмнэлзүйн ганцаарчилсан ярилцлага хийж сэтгэл гутрах эмгэгийг оношилсон.

**Эдинбургийн сорил:** Эдинбургийн төрсний дараах сэтгэл гутралыг ирүүлэх асуумж (EPDS)-ийг анх 1987 онд Кокс болон түүний хамтрагчид төрсний дараах үеийн сэтгэл гутралыг илрүүлэх зорилгоор тусгайлан боловсруулсан хэдий ч орчин үед олон улсад жирэмсэн болон төрсний дараах сэтгэл гутралыг илрүүлэхэд хамгийн түгээмэл хэрэглэгддэг стандарт асуумж болсон. Энэхүү асуумжаар жирэмсэн ба төрсний дараах үеийн сэтгэл гутралыг илрүүлэхэд тусгайлан ашиглаж өвөрмөц болоод найвартай асуумж болохыг нь олон судалгаагаар баталсан байдаг.<sup>66</sup> Тиймээс уг асуумжийн олон улсад мэдрэг чанар нь 59-100%, өвөрмөц байдал нь 49-100%-тай болох нь тогтоогдсон бол Манай улсад анх 2002 онд энэхүү асуумжийг ашиглан төрсний дараах сэтгэл гутралыг илрүүлэх тархалтын судалгаа явуулж мэдрэг чанарыг 86%, өвөрмөц

байдал нь 78%, найдвартай байдлыг Кронбахын альфа коэффициент нь 0.77 гэж сорилын хүчин төгөлдөр байдлыг тогтоожээ. Үүнээс гадна судлаач Abel Fekadu Dadi нарын 2020 онд бичсэн тойм судалгаандаа жирэмсний сэтгэл гутралыг илрүүлэхэд Эдинбургийн сорилыг 101 судалгаанд ашигласан байгаа нь хамгийн түгээмэл хэрэглэгддэг асуумж болохыг харуулж байна. Уг асуумж нь 10 асуулттай бөгөөд асуумжийг бөглөхөд ойролцоогоор 5 минут зарцуулдаг ба 10 дахь асуултаар амия хорлох бодлыг үнэлдэг. Сорилын нийт оноо 13 ба түүнээс дээш байвал сэтгэл гутралтай гэж үзнэ.

**Хоёрдугаарт:** Бие махбодын үзлэг хийх буюу бодит үзлэгийн аргаар arterийн даралт, судасны цохилт гэх мэт бие махбодын ерөнхий үзлэг хийхээс гадна биеийн жин, өндөр хэмжиж биеийн жингийн индексийг тодорхойлсон.

- Биеийн жинг үзэх: Стандартын дагуу баталгаажуулсан Omron электрон жин ашиглан жинг хэмжсэн.
- Биеийн өндөр үзэх: Биеийн өндрийг 2 метр хүртэлх өндрийг миллиметрийн зөрүүний нарийвчлалтайгаар хэмжих хүчин чадалтай, судалгааны зориулалттай “Somatometre-Stanley 04-116” төхөөрөмжийг ашиглан өндрийн утгыг сантиметрээр хэмжсэн.
- Биеийн жингийн индекс үнэлэх: БЖИ= Биеийн жин (кг) / Биеийн өндөр ( $\text{m}^2$ ) томъёог ашиглаж дараах байдлаар үнэлгээ өгсөн. Үүнд:
  - $18.5 \text{ кг}/\text{m}^2 >$  Биеийн жингийн алдагдалтай
  - $18.5-24.9 \text{ кг}/\text{m}^2$  Хэвийн жинтэй
  - $25.0-29.9 \text{ кг}/\text{m}^2$  Илүүдэл жинтэй
  - $30.0-34.9 \text{ кг}/\text{m}^2$  Таргалалтын I зэрэг
  - $35.0-39.9 \text{ кг}/\text{m}^2$  Таргалалтын II зэрэг
  - $40.0 \text{ кг}/\text{m}^2 <$  Таргалалтын III зэрэг

### 3.5 Судалгааны үр дүнгийн боловсруулалт

Судалгааны үр дүнгийн боловсруулалтыг SPSS 24.0 программд шивж орууллаа. Судалгааны үр дүнг дескриптив аргыг ашиглаж үзүүлэлтүүдийн эзлэх хувь ба тоон утга, тархалт, дундаж, стандарт хазайлт зэргийг тооцоолж тархалтыг хэвийн эсэхийг тодорхойлсны дараа хамаарлыг Пирсоны хи квадрат, корреляци, энгийн шугаман регресс зэрэг аргыг ашиглаж, р-утгыг 0.05-аас бага тохиолдолд статистик ач холбогдолтой гэж үзлээ. Эрсдэлт хүчин зүйлийг үнэлэхдээ нэг ба олон хүчин зүйлсийн логистик регрессийн шинжилгээний арга ашиглан хийж, р утга 0.05–аас бага байх тохиолдолд статистик ач холбогдол бүхий гэж үзсэн.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

### 4.1 ХҮН АМ ЗҮЙН ЕРӨНХИЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Бидний судалгаанд Улаанбаатар хотын нийт 4 дүүрэг, хөдөө орон 11 аймгийн 18-46 насны нийт 1482 жирэмсэн эх хамрагдсаны дундаж нас нь  $30.12 \pm 5.88$  байлаа.

#### Хүснэгт 1. Хүн ам зүйн ерөнхий үзүүлэлтүүд

Үзүүлэлтүүд		Тоо	Хувь
<b>Насны бүлэг</b>	≤19	26	1.8
	20-24	278	18.7
	25-29	368	24.8
	30-34	434	29.3
	35-39	294	19.9
	≥40	81	5.5
<b>Харьяалал</b>	Улаанбаатар хот	743	50.1
	Хөдөө орон нутаг	739	49.9
<b>Яс үндэс</b>	Халх	1297	87.5
	Захчин	34	2.3
	Баяд	33	2.2
	Дөрвөд	30	2.0
	Казак	22	1.5
	Буриад	15	1.0
<b>Боловсрол</b>	Бусад	51	3.4
	Бичиг үсэгт тайлagmaагүй	10	0.7
	Бичиг үсэг тайлagmaсан	25	1.7
	Бага	11	0.7
	Бүрэн бус дунд	92	6.2
	Бүрэн дунд	423	28.5
<b>Хөдөлмөр эрхлэлт</b>	Тусгай дунд/коллеж	132	8.9
	Дээд	712	48.0
	Магистр ба Доктор	77	5.2
	Төрийн байгууллага	381	25.7
	Хувийн хэвшлийн байгууллага	332	22.4
	Хувиараа хөдөлмөр эрхэлдэг	227	15.3
<b>Гэр бүлийн байдал</b>	Тогтмол цалингүй, цагийн ажил хийдэг	25	1.7
	Оюутан	106	7.1
	Гэрийн ажилтай	228	15.4
	Ажилгүй /ажлын чадвартай/	101	6.8
	Хөдөлмөрийн чадвараа алдсан тул группд 13 байдаг	13	0.9
	Малчин	69	4.7
	Салсан ба бэлэвсэн/ ганц бие/	10	0.7
	Огт гэрлэж байгаагүй ганц бие ээж	40	2.7
	Тусдаа амьдарч байгаа / гэр бүл салаагүй ч/	58	3.9
	Хамтран амьдрагчтай	343	23.1
	Гэрлэсэн / Хууль ёсны гэр бүлтэйгээ хамт амьдардаг/	1031	69.6


	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ ба түүнээс бага	177	11.9
<b>Өрхийн орлого</b>	421000-999000	340	22.9
	1000000-1499000	324	21.8
	1500000-1999000	271	18.3
	$\geq 2000000$	370	25.0
	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ ба түүнээс бага	674	45.4
<b>Хувь хүний орлого</b>	421000-999000	543	36.6
	1000000-1499000	181	12.2
	$>1500000$	84	5.7
<b>НИЙТ</b>		<b>1483</b>	<b>100.0</b>

Хүснэгт 1-ээс харахад бидний судалгаанд 50.1% (n=743) нь Улаанбаатар хотоос, 49.9% (n=739) нь хөдөө орон нутагт оршин суудаг эхчүүд хамрагдсан байна.

Жирэмсэн эхчүүдийн насын бүлгийг судалж үзэхэд 30-35 нас (29.3%, n=368) болон 25-30 насынхан (24.8%, n=278) дийлэнхи хамрагдсан бол 18-19 насынхан хамгийн бага буюу 1.8% (n=26) хамрагдсан байна. Мөн судалгаанд хамрагдагсдын дийлэнх хувийг халх үндэстэн 87.5% (n=1297) эзэлж байсан.

Боловсролын хувьд 48.0% (n=712) нь дээд, 28.5% (n=432) нь бүрэн дунд боловсролтой байв. Хөдөлмөр эрхлэлтийг судалж үзэхэд судалгаанд хамрагдсан эхчүүдийн 25.8% (n=382) нь төрийн байгууллагад ажиллаж байгаа бол 22.4% (n=332) нь хувийн хэвшлийн байгууллагад, 15.3% (n=227) нь хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа бол 15.4% (n=228) нь гэрт сууж гэрийн ажлаа хийдэг гэжээ. Гэр бүлийн байдлыг судалж үзэхэд эхчүүдийн 69.6% (n=1031) нь хууль ёсны гэр бүлтэйгээ, 23.1% (n=343) нь хамтран амьдрагчтайгаа хамт амьдарч байна. Харин үлдсэн хувь нь гэр бүл салаагүй ч тусдаа амьдардаг (3.9%, n=58), огт гэрлэж байгаагүй (2.7%, n=40), салсан болон бэлэвсэн (0.7%, n=10) гэсэн шалтгаанаар ганц бие жирэмсэн эхчүүд амьдарч байна.

Жирэмсэн эхчүүдийн өрхийн болон хувь хүний сарын орлогыг судалж үзэхэд судалгаанд хамрагдагсдын өрхийн орлогын 25.0% (n=370) 2 сая ба түүнээс дээш, 22.9% (n=340) нь 421000-999000 төгрөгийн орлоготой байна. Харин хувь хүний буюу жирэмсэн эхчүүдийн орлогын ойролцоогоор 50 орчим хувьд (45.4%, n=674) нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ ба түүнээс доош, 36.6% (n=543) 421000-999000 төгрөгийн орлоготой байлаа. Энэ нь жирэмсэн эхчүүдийн өөрийн орлого харьцангуй бага байгааг харуулж байна.



**Зураг 2. Судалгаанд хамрагдсан эхчүүдийн оршин сууж буй харьяалал**

Зураг 2-оос харахад 21.8% (n=323) нь Улаанбаатар хотын Баянзүрх дүүргээс, 17.2% (n=255) нь Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргээс, 9.8% (n=145) Улаанбаатар хотын Чингэлтэй дүүргээс, 1.3% (n=20) нь Улаанбаатар хотын Багануур дүүргээс тус тус хамрагдсан бол Дундговь 2.4% (n=36), Хэнтий 2.9% (n=43), Говь-Алтай 3.2% (n=48) зэрэг аймгуудаас хамгийн цөөн эхчүүд хамрагдсан байна.

#### **Хүснэгт 2. Судалгаанд хамрагдсан эхчүүдийн жирэмслэлт ба төрөлтэй холбоотой үзүүлэлтүүд**

Үзүүлэлтүүд	Тоо	Хувь
Жирэмсний хугацаа		
Эхний 3 сар	118	8.0
Дунд 3 сар	951	64.2
Сүүлийн 3 сар	413	27.8
Төлөвлөөгүй буюу санаандгүй жирэмслэлт		
Тийм	522	35.2
Үгүй	960	64.8
Хүсээгүй жирэмслэлт		
Тийм	56	3.8
Үгүй	1426	96.2

<b>Жирэмслэлтийн тоо</b>		
1	271	18.3
2-4	947	63.9
≥5	264	17.8
<b>Жирэмслэлт таслуулж байсан эсэх (Аборт)</b>		
Тийм	341	23.0
Үгүй	1141	77.0
<b>Төрөлт</b>		
Анхан төрөлт	340	22.9
Давтан төрөлт	1142	77.1
<b>Амьгүй төрөлт</b>		
Тийм	92	6.2
Үгүй	1390	93.8
<b>Хүүхдийн тоо</b>		
Хүүхэдгүй	332	22.4
1-3 хүүхэдтэй	1053	71.0
4-5 хүүхэдтэй	91	6.2
6 ба түүнээс дээш хүүхэдтэй	6	0.4

Хүснэгт 2-оос харахад судалгаанд хамрагдагсдын жирэмсний хугацааг судлаж үзэхэд 64.2% (n=951) нь жирэмсний дунд гурван сардаа буюу жирэмсний 13-27 долоо хоногтой эхчүүд, 27.8% (n=413) нь жирэмсний сүүлийн гурван сардаа буюу жирэмсний 28-40 долоо хоногтой эхчүүд, 8.0% (n=118) нь жирэмсний эхний гурван сардаа буюу жирэмсний 1-12 долоо хоногтой эхчүүд хамрагдсан байв.

Тэдний 35.2% (n=522) нь тухайн хүүхдээ төлөвлөж байж жирэмсэлсэн бол 64.8% (n=960) нь санаандгүй буюу хүүхэдтэй болно гэж төлөвлөөгүй байх үедээ жирэмсэлсэн байна. Харин судалгаанд хамрагдагсдын 3.8% буюу 56 эх тухайн жирэмслэлтээ хүсээгүй гэж хариулжээ. Жирэмслэлтийн тоог судлахад судалгаанд хамрагдагсдын 63.9% (n=947) нь 2-4 удаа, 18.3% (n=271) нь анх удаагаа, 17.8% (n=264) нь 5 ба түүнээс дээш удаа жирэмсэлсэн байв. Харин 23.0% (n=341) нь урьд нь жирэмслэлтээ таслуулж байсан түүхтэй байлаа.

Төрөлтийн талаарх мэдээлэл: Судалгаанд хамрагдагсдын 22.9% (n=340) нь анхан, 77.1% (n=1142) давтан төрөлт байсан бол 71.0% (n=1053) нь 1-3 хүүхэдтэй, 6.2% (n=91) нь 4-5 хүүхэдтэй, 0.4% (n=6) нь 6 ба түүнээс дээш хүүхэдтэй байв.

### **Хүснэгт 3. Судалгаанд хамрагдсан эхчүүдийн удамзүй ба хорт зуршилтай холбоотой мэдээллүүд**

<b>Үзүүлэлтүүд</b>	<b>Toо</b>	<b>Хувь</b>
<b>Удамдаа сэтгэцийн эмгэгтэй хүн бий эсэх</b>		
Тийм	24	1.6
Үгүй	1458	98.4
<b>Амьдралдаа архи хэрэглэж эсэх</b>		
Тийм	321	21.7
Үгүй	1161	78.3

<b>Тамхи</b>			
Огт татдаггүй	1303	87.9	
Өмнө нь татдаг байсан	142	9.6	
Одоо татдаг	37	2.5	
<b>Кофены хэрэглээ</b>			
Тийм	239	16.1	
Үгүй	1243	83.9	
<b>Мансууруулах болон сэтгэц нөлөөт эмийн хэрэглээ</b>			
Тийм	4	0.3	
Үгүй	1478	99.7	
<b>Нойрсуулах үйлдэлтэй эмийн хэрэглээ</b>			
Тийм	21	1.4	
Үгүй	1461	98.6	

Судалгаанд хамрагдсан эхчүүдийн уdam зүй, хорт зуршил зэргийг судалж үзэхэд 1.6% (n=24) нь уdamдаа сэтгэцийн ямар нэгэн эмгэгтэй хүнтэй байлаа.

Харин эхчүүдийн 21.7% (n=321) нь архи ба согтууруулах ундааг ямар нэгэн хэмжээгээр хэрэглэдэг, 2.5% (n=37) нь тамхи татдаг, 9.6% (n=142) нь өмнө нь тамхи татаж байгаад больсон, 16.1% (n=239) нь тогтмол кофе хэрэглэдэг, 0.3% (n=4) нь сэтгэц нөлөөт эм, 1.4% (n=21) нь нойрсуулах үйлдэлтэй эм тогтмол хэрэглэдэг байна (Хүснэгт 3).

Судалгаанд хамрагдагсдын гэр бүлийн харилцааг судалж үзэхэд 88.9% (n=1318) нь ямар нэгэн стрессгүй тайван амгалан санаа зовох зүйлгүй амьдардаг гэж хариулсан бол 7.8% (n=115) нь нөхрийн талаас дэмжлэг дутмаг, 3.8% (n=38) нөхөртэйгөө ойлголцож чаддаггүй ч бусад хүмүүсийн нүдэнд эв найртай гэр бүл шиг харагддаг, 2.6% (n=38) нь нөхөр ажил хийдэггүй тул маргалдах зүйл их гардаг, 0.9% (n=13) нь нөхөр нь архи ууж агсан тавьдаг тул айдаг байдал их гардаг 0.9% (n=14) нь эв түнжин муутай байдаг гэж хариулжээ.

Харин хамаатан садан болон найз нөхдийн тусlamж дэмжлэг хэр байгааг судалж үзэхэд 3.5% (n=52) нь гэр бүл, найз нөхдийн зүгээс тусlamж дэмжлэг багатай, 5.6% (n=83) нь нөхөртэйгөө харьцаа сайтай боловч хадам эцэг эхийн оролцоо хэт их, дарамтай, 3.2% (n=48) нь нөхөртэйгөө харьцаа сайтай боловч өөрийн эцэг эхийн оролцоо хэт их, дарамттай, дэмжлэг муутай амьдардаг байлаа (Хүснэгт 4).

#### **Хүснэгт 4. Судалгаанд хамрагдсан эхчүүдийн гэр бүлийн харилцаа ба дэмжлэгийг судалсан байдал**

<b>Үзүүлэлтүүд</b>	<b>Тоо</b>	<b>Хувь</b>	
Тайван амгалан санаа зовох зүйлгүй	Тийм	1318	88.9
	Үгүй	164	11.1
Нөхрийн зүгээс сэтгэл санаа, эдийн засгийн дэмжлэг	Тийм	115	7.8
дутмаг	Үгүй	1367	92.2
Нөхөр ажил хийдэггүй тул маргалдах зүйл их гардаг	Тийм	38	2.6

	Үгүй	1444	97.4
Нөхөр архи ууж агсан тавьдаг тул айдаг	Тийм	13	0.9
	Үгүй	1469	99.1
Нөхөртэйгээ ойлголцож чаддаггүй ч бусад	Тийм	57	3.8
хүмүүсийн нүдэнд эв найртай гэр бүл шиг харагдаг	Үгүй	1425	96.2
Эв түнжин муутай байдаг	Тийм	14	0.9
	Үгүй	1468	99.1
Гэр бүл, найз нөхдийн зүгээс тусlamж дэмжлэг	Тийм	52	3.5
багатай	Үгүй	1430	96.5
Нөхөртэйгээ харьцаа сайтай боловч хадам эцэг	Тийм	83	5.6
эхийн оролцоо хэт их байдаг нь хэцүү байдаг	Үгүй	1399	94.4
Нөхөртэйгээ харьцаа сайтай боловч миний өөрийн	Тийм	48	3.2
эцэг эхийн оролцоо хэт их байдаг нь хэцүү байдаг	Үгүй	1434	96.8

**Хүснэгт 5. Одоогийн хүчирхийлэлд өртөж буй байдлыг  
тодорхойлсон үзүүлэлтүүд**


Үзүүлэлтүүд	Toо	Хувь	
Ямар нэгэн хүчирхийлэлд өртөөгүй	Тийм	1373	92.7
	Үгүй	109	7.4
Бие махбодын хүчирхийлэлд өртдөг	Тийм	19	1.3
	Үгүй	1463	98.7
Эдийн засгийн хүчирхийлэлд өртдөг	Тийм	40	2.7
	Үгүй	1442	97.3
Сэтгэл санааны хүчирхийлэлд өртдөг	Тийм	50	3.4
	Үгүй	1432	96.6
Үл хайхрах хүчирхийлэлд өртдөг	Тийм	37	2.5
	Үгүй	1445	97.5
Бэлгийн хүчирхийлэлд өртдөг	Тийм	5	0.3
	Үгүй	1476	99.7
Бусад	Тийм	17	1.1
	Үгүй	1465	98.9

Хүснэгт 5-аас харахад судалгаанд хамрагдагсдын 92.7% (n=1373) хүчирхийлэлд өртөөгүй гэж хариулсан байна. Харин 1.3% (n=19) бие махбодын, 2.7% (n=19) нь эдийн засгийн, 3.4% (n=19) нь сэтгэл санааны, 2.5% (n=19) нь үл хайхрах, 0.3% (n=19) нь бэлгийн хүчирхийлэлд тус тус өртсөн байна.

#### 4.2 СЭТГЭЛ ГУТРАЛЫН ТАРХАЛТ

Бид жирэмсэн эхчүүдийн сэтгэл гутралын тархалтыг олон улсад хамгийн түгээмэл хэрэглэдэг Эдинбургийн стандарт илрүүлгийн асуумжийг ашиглаж үнэлсэн. Уг асуумжийн нийт оноо нь 13 ба түүнээс дээш байгаа тохилдолд сэтгэл

гутралтай гэж үзсэн. Бидний судалгаанд хамрагдагсдын 15.9% (n=235) нь сэтгэл гутралтай гэж оношлогдсон бол 84.1% (n=1247) нь сэтгэл гутралгүй байлаа. (Зураг 2)



**Зураг 3. Жирэмсэн эхчүүдийн сэтгэл гутралын (Эдинбургийн асуумж) тархалт**

**Хүснэгт 6. Сэтгэл гутралыг хүн ам зүйн үзүүлэлттэй харьцуулсан дүн**

Үзүүлэлтүүд	Эдинбургийн асуумж		Нийт	*Р утга
	Гутралтай n (%)	Гутралгүй n (%)		
<b>Насны бүлэг</b>				
≤19	18 (69.2)	8 (30.8)	26 (1.8%)	0.001
20-24	60 (21.6)	218(78.4)	278 (18.7%)	
25-29	58 (15.8)	310 (84.2)	368 (24.8%)	
30-34	71 (16.4)	363 (83.6)	434 (29.3%)	
35-39	30 (10.2)	265 (89.8)	295 (19.9%)	
≥40	8 (9.9)	73 (90.1)	81 (5.5%)	
<b>Харьяалал</b>				
Улаанбаатар хот	85 (11.5)	654 (88.5)	739 (50.1%)	0.000
Хөдөө орон нутаг	150 (20.2)	593 (79.8)	743 (49.9%)	
<b>Яс үндэс</b>				
Халх	210 (16.2)	1087 (83.8)	1297 (87.5%)	0.767
Захчин	3 (8.8)	31 (91.2)	34 (2.3%)	

Баяд	6 (18.2)	27 (81.8)	33 (2.2%)	
Дөрвөд	4 (13.3)	26 (86.7)	30 (2.0%)	
Казак	4 (18.2)	18 (81.8)	22 (1.5%)	
Буриад	3 (20.0)	12 (80.0)	15 (1.0%)	
Бусад	5 (9.8)	46 (90.2)	51 (3.4%)	
<b>Боловсрол</b>				
Бичиг үсэгт тайлагдаагүй	2 (20.0)	8 (80.0)	10 (0.7%)	0.083
Бичиг үсэг тайлагдсан	3 (12.0)	22 (88.0)	25 (1.7%)	
Бага	4 (36.4)	7 (63.6)	11 (0.7%)	
Бүрэн бус дунд	14 (15.2)	78 (84.8)	92 (6.2%)	
Бүрэн дунд	66 (15.6)	357 (84.4)	423 (28.5%)	
Тусгай дунд/коллеж	31 (23.5)	101 (76.5)	132 (8.9%)	
Дээд	108 (15.2)	604 (84.8)	712 (48.0%)	
Магистр,Доктор	7 (9.1)	70 (90.9)	77 (5.2%)	
<b>Хөдөлмөр эрхлэлт</b>				
Төрийн байгууллага	37 (9.7)	344 (90.3)	381 (25.7%)	0.001
Төрийн бус байгууллага	60 (18.1)	272 (81.9)	332 (22.4%)	
Хувиараа хөдөлмөр	36 (15.9)	191 (84.1)	227 (15.3%)	
эрхэлдэг				
Тогтмол цалингүй, цагийн	21 (84.0)	4 (16.0)	25 (1.7%)	
ажил хийдэг				
Оюутан	29 (27.4)	77 (72.6)	106 (7.1%)	
Гэрийн ажилтай	44 (19.3)	184 (80.7)	228 (15.4%)	
Ажилгүй /ажлын чадвартай/	15 (14.9)	86 (85.1)	101 (6.8%)	
Хөдөлмөрийн чадвараа	3 (23.1)	10 (76.9)	13 (0.9%)	
алдсан тул группд байдаг				
Малчин	7 (10.1)	62 (89.9)	69 (4.7%)	
<b>Гэр бүлийн байдал</b>				
Огт гэрлэж байгаагүй ганц	7 (17.5)	33 (82.5)	40 (2.7%)	
бие				0.007
Хууль ёсны гэр бүлтэйгээ	140 (13.6)	891 (86.4)	1031 (69.6%)	
хамт амьдардаг				
Тусдаа амьдардаг /гэр бүл	14 (24.1)	44 (75.9)	58 (3.9%)	
салаагүй ч/				
Салсан /ганц бие ээж /	2 (20.0)	8 (80.0)	10 (0.7%)	
Хамтран амьдрагчтай	72 (21.0)	271 (79.0)	343 (23.1%)	
<b>Удамдаа сэтгэцийн эмгэгтэй хүнтэй</b>				
Тийм	9 (37.5)	15 (62.5)	24 (1.6%)	
Үгүй	226 (15.5)	1232 (84.5)	1458 (98.4%)	
<b>НИЙТ</b>	<b>235 (15.9)</b>	<b>1247 (84.1)</b>	<b>1482 (100.0)</b>	

\*Chi-square test

Хүснэгт 6-аас харахад 19 ба түүнээс доош насны эхчүүдийн 69.2% (n=18), 20-24 настай эхчүүдийн 21.6% (n=60), 25-29 настай эхчүүдийн 15.8% (n=58), 30-34 настай эхчүүдийн 16.4% (n=71), 35-39 настай эхчүүдийн 10.2% (n=30), 40 ба түүнээс дээш настай эхчүүдийн 9.9% (n=8) нь сэтгэл гутралтай байсан бөгөөд жирэмсэн эхийн нас залуу байх тусам сэтгэл гутрах эмгэгээр өвдөх эрсдэлтэй байх магадлалтай гэсэн статистик ач холбогдол бүхий ( $p=0.001$ ) хамааралтай байна.

Улаанбаатар хотын эхчүүдийн 11.5% (n=85), хөдөө орон нутагт амьдардаг эхчүүдийн 20.2% (n=150) нь сэтгэл гутралтай гэсэн статистик ач холбогдол ( $p<0.001$ ) бүхий ялгаатай үзүүлэлт гарсан. Харин тогтмол цалингүй, цагийн ажил хийдэг эхчүүдийн 84.0% (n=21) нь сэтгэл гутралтай байсан бол оюутан эхчүүдийн 27.4% (n=29) сэтгэл гутралтай байсан. Боловсролын хувьд бага болон түүнээс доош боловсролтой жирэмсэн эхчүүд сэтгэл гутрал их, дээд болон эрдмийн зэрэг цолтой жирэмсэн эхчүүд сэтгэл гутралын түвшин бага байлаа. Харин төрийн байгууллагад ажиллаж байгаа эхчүүд (9.7%, n=37) хамгийн сэтгэл гутралтай байсан. Энэхүү ялгаатай үзүүлэлтүүд нь статистик ач холбогдол ( $p=0.001$ ) бүхий байлаа.

Гэр бүлийн байдлыг судалж үзэхэд гэр бүл салаагүй ч тусдаа амьдарч байгаа (n=14, 24.1%), хамтран амьдрагчтай (n=72, 21.0%), нөхрөөсөө салсан ганц бие (n=2, 20.0%) эхчүүд хамгийн их сэтгэл гутралтай байгаа бол огт гэрлэж байгаагүй ганц бие эхчүүдийн 17.5% (n=7) нь сэтгэл гутралтай байв. Харин хууль ёсны гэр бүлтэйгээ хамт амьдардаг эхчүүд (n=140, 13.6%) нь хамгийн бага хувь сэтгэл гутралтай гэсэн статистик ач холбогдол ( $p=0.007$ ) бүхий ялгаатай байв.

Жирэмсэн эхчүүдийн жирэмслэлтийн байдал болон төрөлтийн мэдээллүүдийг сэтгэл гутралтай харьцуулж судлахад төлөвлөөгүй буюу санаандгүй жирэмслэлт (21.5%, n=112) нь төлөвлөсөн жирэмслэлтэй (12.8%, n=123) харьцуулахад илүү сэтгэл гутралтай ( $p<0.001$ ) байгаа нь статистикаар батлагдсан. (Хүснэгт 7) Мөн анхны жирэмсэн эхчүүдийн 19.6% (n=53) нь, 2-4 дэх хүүхдээ тээж байгаа эхчүүдийн 14.0% (n=133) нь, 5 ба түүнээс дээш жирэмсэлж байгаа эхчүүдийн 18.6% (n=49) нь сэтгэл гутралтай байсан бөгөөд анх удаа жирэмсэн болж байгаа эхчүүд нь давтан жирэмсэлж байгаа эхчүүдээс арай илүү сэтгэл гутрах эмгэгээр өвдсөн гэсэн статистик ач холбогдол бүхий ( $p=0.038$ ) ялгаа ажиглагдлаа. Харин удамдаа ямар нэгэн сэтгэцийн эмгэгтэй хүнтэй (n=9, 37.5%) жирэмсэн эхчүүд нь удамдаа сэтгэцийн эмгэгтэй хүн байхгүй эхчүүдээс (n=226, 15.5%) арай илүү хувьтай сэтгэл гутрах эмгэгээр өвдсөн ( $p=0.003$ ) байна нь статистикаар батлагдав. (Хүснэгт 7)

**Хүснэгт 7. Сэтгэл гутралыг жирэмслэлт болон төрөлтийн үзүүлэлттэй харьцуулсан дүн**

Үзүүлэлтүүд	Эдинбургийн асуумж		Нийт n=1482	*Р утга
	Гутралтай n (%)	Гутралгүй n (%)		
<b>Жирэмсний хугацаа</b>				
Эхний 3 сар	19 (16.1)	99 (83.9)	118 (8.0%)	
Дунд 3 сар	156 (16.4)	795 (83.6)	951 (64.2%)	0.682
Сүүлийн 3 сар	60 (14.5)	353 (85.5)	413 (27.8%)	
<b>Төлөвлөөгүй, санаандгүй жирэмслэлт</b>				
Тийм	112 (21.5)	410 (78.5)	522 (35.2%)	
Үгүй	123 (12.8)	837(87.2)	960 (64.8%)	0.000
<b>Хүсээгүй жирэмслэлт</b>				
Тийм	13 (23.2)	43 (76.8)	56 (3.8%)	
Үгүй	222 (15.6)	1204 (84.4)	1426 (96.2%)	0.124
<b>Жирэмслэлтийн тоо</b>				
1 удаа	53 (19.6)	218 (80.4)	271 (18.3%)	
2-4 удаа	133 (14.0)	814 (86.0)	947 (63.9%)	0.038
≥5 удаа	49 (18.6)	215 (81.4)	264 (17.8%)	
<b>Жирэмслэлт таслуулж байсан эсэх</b>				
Тийм	60 (17.6)	281 (82.4)	341 (23.0%)	0.317
Үгүй	175 (15.3)	966 (84.7)	1141 (77.0%)	
<b>Төрөлт</b>				
Анхан	58 (17.1)	282 (82.9)	340 (22.9%)	0.489
Давтан	177 (15.5)	965 (84.5)	1142 (77.1%)	
<b>Амьгүй төрөлт</b>				
Тийм	15 (16.3)	77 (83.7)	92 (6.2%)	0.903
Үгүй	220 (15.8)	1170 (84.2)	1390 (93.8%)	
<b>Хүүхдийн тоо</b>				
Хүүхэдгүй	57 (17.2)	275 (82.8)	332 (22.4%)	
1-3 хүүхэдтэй	166 (15.8)	887 (84.2)	1053 (71.0%)	
4-5 хүүхэдтэй	11 (12.1)	80 (87.9)	91 (6.2%)	0.704
6 ба түүнээс дээш хүүхэдтэй	1 (16.7)	5 (83.3)	6 (0.4%)	
<b>Нийт</b>	<b>336 (22.7)</b>	<b>1146 (77.3)</b>	<b>1482 (100.0)</b>	

\*Chi-square test

Бид судалгаанд хамрагдагсдын гэр бүлийн харилцаа ба сэтгэл гутралын хоорондын хамаарлыг шалгаж үзэхэд гэр бүлийн харилцаа нь эв түнжин муутай эхчүүдийн 64.3% (n=9, p<0.001), нөхөртэйгээ ойлголцож чаддаггүй ч бусад хүмүүсийн нүдэнд эв найртай гэр бүл шиг харагддаг эхчүүдийн 49.1% (n=28, p<0.001), нөхөр нь ажил хийдэггүй тул маргалдах зүйл их гардаг харилцаатай эхчүүдийн 36.8% (n=14, p<0.001) нь, нөхрийн зүгээс сэтгэл санаа, эдийн засгийн дэмжлэг дутмаг эхчүүдийн 33.0% (n=38, p<0.001) нь сэтгэл гутралтай байхад харьцангуй тайван амгалан санаа зовох зүйлгүй гэр бүлд амьдарч байгаа эхчүүд

нь (12.8%, n=169, p<0.001) нь харьцангуй бага сэтгэл гутралд өртөж байгаа нь статистик ач холбогдол бүхий батлагдсан.

Харин гэр бүл, найз нөхдийн зүгээс тусламж дэмжлэг багатай эхчүүдийн 46.2% (n=24, p<0.001), нөхөртэйгөө харьцаа сайтай боловч хадам эцэг эхийн оролцоо хэт их байдаг нь хэцүү байдаг гэсэн эхчүүдийн 36.1% (n=30, p<0.001), нөхөртэйгөө харьцаа сайтай боловч миний өөрийн эцэг эхийн оролцоо хэт их байдаг нь хэцүү байдаг гэсэн эхчүүдийн 35.4% (n=17, p<0.001) сэтгэл гутрах эмгэгтэй байна. (Хүснэгт 8)

#### **Хүснэгт 8. Гэр бүлийн харилцаа ба сэтгэл гутралын хоорондын хамаарлыг үнэлсэн үзүүлэлт**

Үзүүлэлтүүд	Эдинбургийн асуумж		Нийт n=1482	*Р утга
	Гутралтай	Гутралгүй		
Тайван амгалан санаа зовох зүйлгүй	169 (12.8)	1149 (87.2)	1318 (88.9)	0.001
Нөхрийн зүгээс сэтгэл санаа, эдийн засгийн дэмжлэг дутмаг	38 (33.0)	77 (67.0)	115 (7.8)	0.001
Нөхөртэйгөө харьцаа сайтай боловч хадам эцэг эхийн оролцоо хэт их байдаг нь хэцүү байдаг	30 (36.1)	53 (63.9)	83 (5.6)	0.001
Нөхөртэйгөө харьцаа сайтай боловч миний өөрийн эцэг эхийн оролцоо хэт их байдаг нь хэцүү байдаг	17 (35.4)	31 (64.6)	48 (3.2)	0.001
Нөхөр ажил хийдэггүй тул маргалдах зүйл их гардаг	14 (36.8)	24 (63.2)	38 (2.6)	0.001
Нөхөр архи ууж агсан тавьдаг тул айдаг	4 (30.8)	9 (69.2)	13 (0.9)	0.139
Нөхөртэйгөө ойлголцож чаддаггүй ч бусад хүмүүсийн нүдэнд эв найртай гэр бүл шиг харагддаг	28 (49.1)	29 (50.9)	57 (3.8)	0.001
Эв түнжин муутай байдаг	9 (64.3)	5 (35.7)	14 (0.9)	0.001
Гэр бүл, найз нөхдийн зүгээс тусламж дэмжлэг багатай	24 (46.2)	28 (53.8)	52 (3.5)	0.001
<b>Нийт</b>	<b>235 (15.9)</b>	<b>1247 (84.1)</b>	<b>1482 (100.0)</b>	

\*Chi-square test

Хүснэгт 9-өөс харахад биеийн жингийн индекс ба сэтгэл гутрал нь хоорондоо хамааралгүй байв (p=0.472).

#### **Хүснэгт 9. Биеийн жингийн индекс ба сэтгэл гутрал хоорондын хамаарлыг харьцуулсан дүн**

Биеийн индекс	Сэтгэл		Сэтгэл гутралгүй	Нийт n (%)	*Р утга
	жингийнгутралтай	n (%)			
Хэвийн жинтэй	102 (17.1)	493 (82.9)	595 (100)		0.472
Илүүдэл жинтэй	92 (15.4)	504 (84.6)	596 (100)		
Таргалалттай	41 (14.1)	250 (85.9)	291 (100)		
<b>НИЙТ</b>	<b>235 (15.9)</b>	<b>1247 (84.1)</b>	<b>1482 (100.0%)</b>		

### 4.3 ЖИРЭМСНИЙ СЭТГЭЛ ГУТРАЛД НӨЛӨӨЛӨХ ЭРСДЭЛТ ХҮЧИН ЗҮЙЛ

Бид жирэмсэн эхчүүдийн сэтгэл гутралаар өртөх эрсдэлт хүчин зүйлсийг корреляци, энгийн болон олон хүчин зүйлийн логистик регрессийн аргуудаар судалсан.

**Хүснэгт 10. Энгийн логистик регрессийн аргаар жирэмсэн эхчүүдийн сэтгэл гутралд нөлөөлж буй эрсдэлт хүчин зүйлийг судалсан дүн**

Үзүүлэлтүүд	Total	B	P value	OR	95% Confidence Interval for Exp(B)	
					Lower	Upper
<b>Насны бүлэг</b>						
≤19	26 (1.8%)	-0.479	0.286	0.619	0.257	1.494
20-24	278 (18.7%)	-0.865	0.054	0.421	0.175	1.014
25-29	368 (24.8%)	-0.821	0.065	0.440	0.184	1.051
30-34	434 (29.3%)	-1.368	0.003	0.255	0.102	0.636
35-39	295 (19.9%)	-1.400	0.013	0.247	0.081	0.746
≥40	81 (5.5%)					
<b>Харьялал</b>						
Хөдөө орон нутаг	739 (49.9)	-0.666	0.001	0.514	0.385	0.686
Улаанбаатар хот	743 (50.1)					
<b>Жирэмсний хугацаа</b>						
Эхний 3 сар	118 (8.0)	-0.397	0.027	0.672	0.473	0.955
Дунд 3 сар	951 (64.2)	-0.065	0.769	0.937	0.609	1.444
Сүүлийн 3 сар	413 (27.8)					
<b>Төлөвлөөгүй буюу санаандгүй жирэмслэлт</b>						
Үгүй	960 (64.8)	0.620	0.000	1.859	1.402	2.464
Тийм	522 (35.2)					
<b>Одоогийн хүчирхийлэл</b>						
Өртсөн	109 (7.4)	-1.737	0.000	0.176	0.117	0.264
Өртөөгүй	1373 (92.7)					
<b>Сэтгэл санааны хүчирхийлэл</b>						
Өртсөн	50 (3.4)	2.195	0.000	8.978	5.003	16.112
Өртөөгүй	1432 (96.6)					
<b>Гэр бүлийн харилцаа</b>						
Тайван санаа зовох зүйлгүй	1318 (88.9)	-1.521	0.000	0.218	0.154	0.310
Санаа зовох зүйлтэй	164 (11.1)					

Хүснэгт 10-т энгийн логистик регрессийн аргаар жирэмсэн эхчүүдийн сэтгэл гутралд нөлөөлж буй эрсдэлт хүчин зүйлийг судалж үзэхэд 40 болон түүнээс дээш насны эхчүүдтэй харьцуулахад 35-39 насныхан 0.2 дахин ( $p=0.013$ ), 30-34 насныхан 0.2 дахин ( $p=0.003$ ) сэтгэл гутрал илрэх эрсдэл буурч байгаа бол хөдөө орон нутагт амьдарч буй жирэмсэн эхчүүд хотод амьдарч буй жирэмсэн эхчүүдээс 0.5 дахин ( $p\leq0.001$ ) их, жирэмсний сүүлийн 3 сартай жирэмсэн

эхчүүдээс жирэмсний эхний 3 сартай эхчүүд 0.6 дахин ( $p=0.027$ ) илүү сэтгэл гутралд өртөж байна.

Мөн жирэмслэлтийг төлөвлөсөн эхчүүдийг төлөвлөөгүй эхчүүдтэй харьцуулахад 1.8 дахин ( $p\leq 0.001$ ), одоогийн хүчирхийлэлд өртсөн жирэмсэн эхчүүдийг хүчирхийлэлд өртөөгүй эхчүүдтэй харьцуулахад 0.2 дахин ( $p\leq 0.001$ ), сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн эхчүүд өртөөгүй эхчүүдээс 8.9 дахин ( $p\leq 0.001$ ), гэр бүлийн харилцааны хувьд тайван амгалан биш жирэмсэн эхчүүд тайван амгалан гэр бүлтэй эхчүүдээс 0.2 дахин ( $p\leq 0.001$ ) их жирэмсний сэтгэл гутралд өртөж байлаа. Тиймээс бид олон хүчин зүйлийн регрессийн аргаар жирэмсэн эхчүүдийн сэтгэл гутралд нөлөөлж буй эрсдэлт хүчин зүйлийг судалсан.

#### **Хүснэгт 11. Олон хүчин зүйлийн логистик регрессийн аргаар жирэмсний сэтгэл гутралд нөлөөлж буй эрсдэлт хүчин зүйлийг үнэлсэн үзүүлэлт**

Үзүүлэлтүүд	Нийт	Р утга	OR	Confidence Interval for Exp(B)	
				Lower	Upper
Intercept		0.006			
<b>Насны бүлэг</b>					
≤19	26 (1.8%)	0.004	6.723	1.846	24.485
20-24	278 (18.7%)	0.001	4.730	1.867	11.987
25-29	368 (24.8%)	0.011	3.200	1.301	7.866
30-34	434 (29.3%)	0.012	3.095	1.288	7.437
35-39	295 (19.9%)	0.421	1.458	0.582	3.656
≤40	81 (5.5%)				
<b>Харьялал</b>					
Хөдөө орон нутаг	739 (49.9)	0.000	1.987	1.456	2.713
Улаанбаатар хот	743 (50.1)				
<b>Жирэмсний хугацаа</b>					
Эхний 3 сар	118 (8.0)	0.236	0.707	0.399	1.253
Дунд 3 сар	951 (64.2)	0.017	0.599	0.393	0.914
Сүүлийн 3 сар	413 (27.8)				
<b>Төлөвлөөгүй буюу санаандгүй жирэмслэлт</b>					
Үгүй	960 (64.8)	0.007	0.655	0.483	0.888
Тийм	522 (35.2)				
<b>Одоогийн хүчирхийлэл</b>					
Өртсөн	109 (7.4)	0.003	2.382	1.349	4.205
Өртөөгүй	1373 (92.7)				
<b>Сэтгэл санааны хүчирхийлэл</b>					
Өртсөн	50 (3.4)	0.002	0.301	0.139	0.651
Өртөөгүй	1432 (96.6)				
<b>Гэр бүлийн харилцаа</b>					
Тайван санаа зовох зүйлгүй	1318 (88.9)	0.000	3.162	2.085	4.796

Жирэмсэн эхчүүдийн нас хэт залуу, хөдөө орон нутагт амьдардаг байх, төлөвлөөгүй жирэмслэлт, хүчирхийлэлтэй орчинд амьдрах, тэр дундаа сэтгэл санааны хүчирхийлэл, гэр бүлийн харилцаа тайван амгалан биш байх зэрэг нь жирэмсний үеийн сэтгэл гутрал үүсэхэд нөлөөлөх эрсдэлт хүчин зүйлс болох нь статистикаар батлагдлаа. Тухайлбал жирэмсэн эхийн нас залуу байх тусмаа сэтгэл гутралд өртөх эрсдэлтэй байна. Өөрөөр хэлбэл 40 болон түүнээс дээш настай эхчүүдтэй харьцуулахад 19 ба түүнээс доош насыхан 6.7 дахин ( $p=0.004$ ), 20-24 насыхан 4.7 дахин ( $p=0.001$ ), 25-29 насыхан 3.2 дахин ( $p=0.011$ ), 30-34 насыхан 3 дахин ( $p=0.012$ ) их нөлөөлж байна.

Оршин суугаа харьяаллын хувьд хөдөө орон нутагт амьдарч буй жирэмсэн эхчүүд хотод амьдарч буй жирэмсэн эхчүүдээс 1.9 дахин ( $p=0.000$ ), жирэмсний сүүлийн 3 сартай жирэмсэн эхчүүдээс жирэмсний дунд 3 сартай эхчүүд 0.5 дахин ( $p=0.017$ ) илүү сэтгэл гутралд өртөх магадлалтай байна.

Жирэмслэлтийг төлөвлөсөн жирэмсэн эхчүүдийг төлөвлөөгүй эхчүүдтэй харьцуулахад 0.6 дахин ( $p=0.007$ ), одоогийн хүчирхийлэлд өртсөн жирэмсэн эхчүүдийг хүчирхийлэлд өртөөгүй эхчүүдтэй харьцуулахад 2.3 дахин ( $p=0.003$ ), сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн жирэмсэн эхчүүд өртөөгүйтэй харьцуулахад 0.3 дахин ( $p=0.002$ ), гэр бүлийн харилцааны хувьд тайван амгалан биш жирэмсэн эхчүүд тайван амгалан гэр бүлтэй эхчүүдээс 3.1 дахин ( $p=0.000$ ) их жирэмсний сэтгэл гутралд өртөх магадлалтай байна.

## ТАВДУГААР БҮЛЭГ. ХЭЛЦЭМЖ

Бид Монгол улсын жирэмсний сэтгэл гутралын тархалт, түүнд нөлөөлөх эрсдэлт хүчин зүйлийг тогтоох зорилгоор Улаанбаатар хотын 4 дүүрэг, хөдөө орон нутгийн 11 аймгийн 12 сумын нийт 80 түүврийн нэгжээс 1482 жирэмсэн эхчүүдийн хамруулж жирэмсний сэтгэл гутралын тархалтыг олон улсад түгээмэл хэрэглэдэг Эдинбургийн илрүүлгийн стандарт асуумжаар үнэлсэн. Бидний судалгааны үр дүнд жирэмсэн үеийн сэтгэл гутралын тархалт 15.9%-тай гарсан нь бусад улс орнуудад хийгдсэн тархалтын дундаж хувьтай ижил байна. Тухайлбал жирэмсэн эмэгтэйчүүдийн 5-16%-д нь жирэмсний тодорхой хугацаанд нь сэтгэл гутралтай байсан нь тогтоогджээ.<sup>3-6</sup> Жирэмсэн үеийн сэтгэл гутралын тархалт нь жирэмсэн эмэгтэйчүүдийн 16 хүртэлх хувийг эзэлдэг.<sup>7</sup>

Дэлхийн олон оронд хийгдсэн тархалтын судалгааны үр дүнгээс харахад жирэмсэн үеийн сэтгэл гутралын тархалт 10-15 хувь байдаг гэсэн хэдий ч АНУ-д олон жилийн турш хийгдсэн судалгаанд 16% -ийн тархалттай байсан.<sup>17</sup>

Харин жирэмсэн үеийн сэтгэл гутралын тархалтыг судалсан метаанализийн тойм судалгаанаас харахад жирэмсэн үеийн сэтгэл гутралын 15-65% ийн тархалттай байсан.<sup>20</sup> Зарим судалгаануудад 4-81% (Австралид 7%, Хонгконгод 4,4%, Финляндад 7,7%, Бангладешэд 18%, Нигерид 24,5%, Этиопид 24,94%, Энэтхэгт 35.7%, Саудын Арабад 31,9%,<sup>18</sup> Пакистанд 42,7%<sup>19</sup>-ийн тархалттай байсан ба жирэмсний сүүлийн саруудад илүүтэй тохиолддог<sup>3-6</sup> гэсэн судалгаатай бидний судалгааны үр дүнд ижил байна. Харин Пакистанд 42,7%, Саудын Арабад 31,9%, Бангладешэд 18%, Нигерид 24,5%, Этиопид 24,94%, Энэтхэгт 35.7% -ийн тархалттай байгаа улс орнуудтай харьцуулахад манай улс бага тархалтай байна. Харин Австралид 7%, Хонгконгод 4,4%, Финляндад 7,7%-ийн тархалттай байгаа гэсэн судалгааны үр дүнтэй харьцуулахад манай улс 2 дахин өндөр тархалттай байлаа.

Энэтхэгийн Мумбай хотод 9.18%, Энэтхэгийн Бенгалорт 12,13%,<sup>16</sup> Бразилийн Рио де Жанеро хотод 14.2%<sup>15</sup> гэсэн судалгаанаас манай улсад хийгдсэн судалгаа бага зэрэг өндөр гарсан байна.

Мөн манай судалгаагаар жирэмсэн үеийн сэтгэл гутрал 15.9 хувьтай байгааг 2011 онд судлаач Roomruangwong нарын 1968-2010 онуудад хийгдсэн метаанализ тойм судалгаатай харьцуулсан. Энэ судалгаагаар Азийн орнуудад жирэмсний сэтгэл гутралын тархалт 20%, Gelaye нарын 1998-2015 онуудад хийгдсэн судалгаануудад 2016 онд тойм судалгаа хийхэд бага дунд орлоготой улс орнуудад жирэмсний сэтгэл гутралын тархалт 25.3% гэж судлагдсанаас манай судалгаа арай бага үзүүлэлттэй гарсан байна.<sup>20</sup>

Харин манай улсын судлаач Т.Мандхай нарын 2020 онд “Google Survey” программ ашиглан, нийгмийн цахим орчиноор 600 жирэмсэн эхээс судалгаа авахад жирэмсэн эхчүүдийн сэтгэл гутралын тархалт 41.2% (N=247), 34.3 % (N=206) нь амиа хорлох бодолтой байсан<sup>26</sup> гэсэн үр дүнгээс бидний судалгааны дун 15.9% буюу бага тархалттай гарсан байна<sup>26</sup>. Энэ нь бидний судалгааны

түүврийн хэмжээ хоёр дахин их байсан нь бага тархалтай гараад нөлөөлсөн байж болно. Нөгөө талаас бидний жирэмсэн эхчүүдтэй нүүр тулсан ярилцлага хийсэн нь онлайнаар алсын зайнаас асуумж бөглүүлэхээс илүү үнэн бодитой, санамсаргүй алдаа гарах магадлалыг бууруулсантай холбоотой байж болох юм.

Хэвлэлийн тоймуудаас судлахад жирэмсэн эхчүүд нь өөртөө итгэлгүй байх, санаа зовох, айх, түгших зэрэг нь жирэмсний сэтгэл гутралын эрсдэлийг нэмэгдүүлдэг.<sup>55</sup> Харин сэтгэл зүй, бие махбод, эдийн засгийн дэмжлэг сайн байх нь жирэмсний сэтгэл гутралын эрсдэлийг бууруулахад эерэг нөлөө үзүүлдэг гэжээ.<sup>55</sup> Тиймээс бид жирэмсний сэтгэл гутралыг үүсгэх зарим эрсдэлүүдийг судлахад Танзани улсын Дара Саламд хийгдсэн Арба Минч, Мизан Аман нарын хийсэн судалгаанд удамд нь сэтгэл гутралаар өвдсөн түүхтэй хүн байх нь жирэмсний сэтгэл гутралаар өвдөхөд хамааралтай байна гэж дүгнэсэн байна.<sup>20,56</sup> Зарим судлаачид удамшлын хүчин зүйл болон нийгэм сэтгэл зүйн дэмжлэг нь жирэмсний сэтгэл гутрал үүсэхэд нөлөөлдөг гэж тайлбарлаж байна.<sup>59</sup> Харин бидний судалгаанд удамдаа ямар нэгэн сэтгэцийн эмгэгтэй хүн (n=9, 37.5%) байх нь удамдаа сэтгэцийн эмгэгтэй хүн байхгүй эхчүүдээс (n=226, 15.5%) арай илүү хувьтай сэтгэл гутрах эмгэгээр өвдсөн ( $p=0.003$ ) нь статистикаар батлагдсан нь дээрх судалгааны үр дүнтэй ойролцоо гарсан. Бид судалгаанд хамрагдагсдын удамд нь сэтгэл гутралтай болон амиа хорлох эрсдэлтэй хүн байсан эсэхийг тодруулж судлаагүй нь манай судалгааны хязгаарлагдмал тал байлаа.

Олон улсад хийгдсэн судалгаануудаас үзэхэд Польш улс, Нигерийн Абеокутагийн хойд муж, Кени, Этиопид зэрэг орны судлаачдийн хийсэн хэд хэдэн судалгаанд жирэмсний сэтгэл гутрал үүсэхэд гэрлэлтийн байдал, жирэмсний төлөвлөлт, сэтгэл зүйн бэлтгэлгүй байх зэрэг нь жирэмсний сэтгэл гутрал үүсгэх хүчин зүйл болж болохыг баталсан байна. Мөн АНУ, Өмнөд Африк, Кени, Этиопид хийгдсэн судалгаануудад мета анализ хийсэн тойм (systematic review and meta-analysis) судалгаанд нийгмийн болон гэр бүлийн дэмжлэг нь мэдэгдэхүйц хамааралтай гарсан байна. Түүнчлэн нийгэм, гэр бүлийн дэмжлэг нь сэтгэцийн эрүүл мэндийг дэмжсэнээр сэтгэл гутралыг бууруулж өгдөг бол нийгэм гэр бүлийн дэмжлэг дутмаг үед жирэмсний сэтгэл гутралаар өвдөх эрсдэлийг нэмэгдүүлдэг байна. Харин манай судалгаанд жирэмслэлтээ төлөвлөсөн эхчүүд нь жирэмслэлтээ төлөвлөөгүй эхчүүдтэй харьцуулахад 0.6 дахин ( $p=0.007$ ), гэр бүлийн харилцааны хувьд тайван амгалан биш жирэмсэн эхчүүд тайван амгалан гэр бүлтэй эхчүүдээс 3.1 дахин ( $p=0.000$ ) их жирэмсний сэтгэл гутралд өртөхөд бие даасан эрсдэлт хүчин зүйл болсон.

Харин нөхрийн зүгээс сэтгэл санаа, эдийн засгийн дэмжлэг дутмаг (33.0%, n=38,  $p<0.001$ ) байх, гэр бүлдээ эв түнжин муутай (64.3%, n=9,  $p<0.001$ ) байх, нөхөртэйгөө ойлголцож чадахгүй (49.1%, n=28,  $p<0.001$ ) байх зэрэг гэр бүлийн тааламжгүй харилцаатай эхчүүд болон эцэг эх, найз нөхдийн зүгээс тусламж дэмжлэг багатай эхчүүд (46.2% n=24,  $p<0.001$ ) нь харьцангуй тайван санаа зовох

зүйлгүй гэр бүлд амьдарч байгаа эхчүүдээс илүү сэтгэл гутралтай байсан нь дээрх судалгаануудын үр дүнтэй ижил төстэй байна.

Жирэмсний сэтгэл гутралд сэтгэл зүй, бие махбод, бэлгийн гэх мэтийн хүчирхийлэл мэдэгдэхүйц нөлөөлдөг болохыг судлаачид онцолж байна. Тухайлбал: Пакистан, Өмнөд Африк, Кенид, Этиопид хийгдсэн судалгаанууд хийгдсэн мета анализ тойм судалгаануудад нөхөр болон хамтран амьдрагчийн бэлгийн хүчирхийлэл нь жирэмсний сэтгэл гутралд мэдэгдэхүйц нөлөөлдөг гэжээ. Мөн хамтрагчийн сэтгэл зүй, бие махбод, бэлгийн хүчирхийлэл нь жирэмсэн үеийн сэтгэл гутралыг үүсгэх хүчин зүйл мөн болохыг баталжээ.<sup>54</sup> Манай судалгаанд тухайн үед хүчирхийлэлд өртсөн байсан жирэмсэн эхчүүдийг хүчирхийлэлд өртөөгүй эхчүүдтэй харьцуулахад 2.3 дахин ( $p=0.003$ ), сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн жирэмсэн эхчүүд өртөөгүй эхчүүдтэй харьцуулахад 0.3 дахин ( $p=0.002$ ) их жирэмсний сэтгэл гутралд өртөх эрсдэлтэй байна гэсэн дүгнэлт нь дээрх судалгаануудын үр дүнтэй ижил байна.

АНУ, Нидерланд, БНХАУ, Японд зэрэг улс оронд хийгдсэн судалгаануудад аборт хийлгэсэн түүх нь эхийн сэтгэл зүйн хүчтэй нөлөөлж сөрөг хариу урвал, сөрөг үр дагавар өгч ч болно. Тиймээс аборт хийсэн түүх нь жирэмсний сэтгэл гутралтай хамааралтай гэжээ.<sup>54</sup> Гэтэл манай судалгаагаар аборт хийлгэсэнтэй хамааралгүй байсан. Үүнийг нарийвчилж судлаагүй нь бидний судалгааны султал байлаа.

Манай судалгаагаар биеийн жингийн индекс нь жирэмсний сэтгэл гутралтай хамааралгүй гарсан нь судлаач B.Sheeba нарын Энэтхэгийн Бангалор хотод 2019 онд 280 жирэмсэн эмэгтэйд хийсэн судалгаагаар хамааралгүй гэсэн судалгаатай адил үр дүн гарсан байна. Мөн биеийн жингийн таргалалт нь нь жирэмсний сэтгэл гутралтай холбоотой гэж зарим судалгаануудад мөн мэдээлсэнээс ялгаатай үр дүн гарсан байна.<sup>16</sup> Манай судалгааны үр дүн нь судлаач Monica Maria нарын 2016 онд Бразилийн Алфена хотод 209 жирэмсэн эмэгтэйд жирэмсний сэтгэл гутрал 14,8%-тай тогтоогдсон бөгөөд жирэмсний хугацаатай харьцуулан үзэхэд сэтгэл гутралтай эмэгтэйчүүдийн 48,4% нь хоёр дахь 3 сард байгаа хэдий ч статистикаар үнэн магадтай нь батлагдаагүй байна гэсэн судалгааны үр дүнтэй адил үр дүн гарсан байна.<sup>15</sup>

### **ДҮГНЭЛТ:**

1. Монгол улсын Улаанбаатар хотын 4 дүүрэг, хөдөө орон нутгийн 11 аймгийн 12 сумын нийт 80 түүврийн нэгжээс 1482 жирэмсэн эхчүүдийн дунд сэтгэл гутралын тархалтыг судалж үзэхэд жирэмсэн үеийн сэтгэл гутрал 15.9 хувьтай байлаа.
2. Жирэмсэн эхчүүдийн нас хэт залуу байх, хөдөө орон нутагт амьдарч байх, төлөвлөөгүй жирэмслэлт, хүчирхийлэлтэй орчинд амьдрах, тэр дундаа сэтгэл санааны хүчирхийлэл, гэр бүлийн харилцаа тайван амгалан биш байх зэрэг нь жирэмсэн үеийн сэтгэл гутрал үүсэхэд нөлөөлөх эрсдэлт хүчин зүйл болох магадлал өндөр байна.
3. Төрсний дараах сэтгэл гутрал 20.3% байв.

## **ЗӨВЛӨМЖ**

1. Жирэмсэн эмэгтэйчүүдийн сэтгэцийн эрүүл мэндийг анхаарах, эрт илрүүлэг хийх, дагаж тусlamж үйлчилгээг үзүүлэх нь эмэгтэйчүүдийн жирэмсэн үеийн эрүүл мэнд төдийгүй цаашдаа эх болон хүүхдийн эрүүл мэндэд сөрөг үр дагавар үүсгэхээс урьдчилан сэргийлэх боломжтой юм.
2. Жирэмсэн болон төрсний дараах үед байгаа эмэгтэйчүүдээс сэтгэл гутралыг илрүүлэх сорилыг доод тал нь 1 удаа заавал авч, эрт илрүүлэг хийх, жирэмснийг хянах болон эх барих эмэгтэйчүүдийн талаархи оношлогоо эмчилгээний стандарт, удирдамжинд нэмж оруулах шаардлагатай байна.
3. Өрх, суманд ажиллаж буй ерөнхий мэргэжлийн эмч нар болон эх барих, эмэгтэйчүүдийн эмч нарт эхийн сэтгэл санааны байдлыг анхаарах, сэтгэл гутралыг илрүүлэх, зөвлөгөө өгөх, шаардлагатай эмчилгээ, тусlamж үйлчилгээ үзүүлэх /эмчилгээний хөтөлбөр, асаргаа сувилгааны менежментийн талаар / талаар мэдээлэл, сургалт явуулах хэрэгтэй.
4. Хүнд сэтгэл гутрал илэрсэн болон эмчилгээний үр дүн тааруу үед аймаг, дүүргийн сэтгэцийн эмчид үзүүлж, тусlamж үйлчилгээ авч хэвших нь эх, ураг, хүүхдийн эрүүл мэнд, хүүхдийн цаашдын сэтгэцийн эрүүл мэндэд чухал ач холбогдолтой.

## НОМ ЗҮЙ

1. P. R. Albert, "Why is depression more prevalent in women?" *Journal of Psychiatry & Neuroscience*, vol. 40, no. 4, pp. 219–221, 2015. View at: [Google Scholar](#)
2. GBD 2017 Disease and Injury Incidence and Prevalence Collaborators, "Global, regional, and national incidence, prevalence, and years lived with disability for 354 diseases and injuries for 195 countries and territories, 1990-2017: a systematic analysis for the Global Burden of Disease Study 2017," *The Lancet*, vol. 392, no. 10159, pp. 1789–1858, 2018. View at: [Publisher Site](#) | [Google Scholar](#)
3. World Health Organization, *Mental Health: A Call for Action*, World Health Ministers, 2001.
4. R. C. Kessler and E. J. Bromet, "The epidemiology of depression across cultures," *Annual Review of Public Health*, vol. 34, pp. 119–138, 2014. View at: [Google Scholar](#)
5. S. Yu, "Uncovering the hidden impacts of inequality on mental health: a global study," *Translational Psychiatry*, vol. 8, pp. 2–10, 2018. View at: [Google Scholar](#)
6. Humayun A, Haider II, Imran N, Iqbal H, Humayun N. Antenatal depression and its predictors in Lahore, Pakistan. *East Mediterr Health J.* 2013; 19:327–32.
7. T. OTEF and P. DFOR, "Depression in pregnant women and mothers: how children are affected," *Paediatrics & Child Health*, vol. 9, no. 8, pp. 584–586, 2004. View at: [Publisher Site](#) | [Google Scholar](#)
8. A. Stein, E. Netsi, P. J. Lawrence et al., "Mitigating the effect of persistent postnatal depression on child outcomes through an intervention to treat depression and improve parenting : a randomised controlled trial," *Lancet Psychiatry*, vol. 5, pp. 134–144, 2018. View at: [Google Scholar](#)
9. Imran N, Haider II. Screening of antenatal depression in Pakistan: risk factors and effects on obstetric and neonatal outcomes. *Asia-Pacific Psychiatry*. 2010; 2:26–32.
10. Zeng et al. Prevalence and predictors of antenatal depressive symptoms among Chinese women in their third trimester: a cross-sectional survey. *BMC Psychiatry* (2015) 15:66 DOI 10.1186/s12888-015-0452-7
11. Kaaya SF, Mbwambo JK, Kilonzo GP, Van Den Borne H, Leshabari MT, Fawzi MC, et al. Socio-economic and partner relationship factors associated with antenatal depressive morbidity among pregnant women in Dar es Salaam, Tanzania. *Tanzan J Health Res.* 2010;12(1):23–35.
12. Faisal-Cury A, Menezes P, Araya R, Zugaib M. Common mental disorders during pregnancy: prevalence and associated factors among low-income women in São Paulo, Brazil. *Arch Women Ment Health.* 2009; 120:335–43.

13. Bennett HA, Einarson A, Taddio A, Koren G, Einarson TR (2004) Prevalence of depression during pregnancy: systematic review. *Obstet Gynecol* 103(4):698–709
14. Fatoye FO, Adeyemi AB, Oladimeji B. Emotional distress and its correlates among Nigerian women in late pregnancy. *J Obstet Gynecol*. 2004; 24:504–9.
15. Silva MMJ, Leite EPRC, Nogueira DA, Clapis MJ. Depression in pregnancy. Prevalence and associated factors. *Invest. Educ. Enferm.* 2016; 34(2): 342-350.DOI: 10.17533/udea.iee.v34n2a14
16. Sheeba B, Nath A, Metgud CS, Krishna M, Venkatesh S, Vindhya J and Murthy GVS. Prenatal Depression and Its Associated Risk Factors Among Pregnant Women in Bangalore: A Hospital Based Prevalence Study. *Front. Public Health* 7:108: 1-2, 7 4doi: 10.3389/fpubh.2019.00108
17. M. Wilcox, B. A. McGee, D. F. Ionescu et al., “Perinatal depressive symptoms often start in the prenatal rather than postpartum period: results from a longitudinal study,” *Archives of Women's Mental Health*, pp. 1–13, 2020. View at: [Publisher Site](#) | [Google Scholar](#)
18. Z. Al-Hejji, M. Al-Khudhair, M. Al-Musaileem, and M. Al-Eithan, “Prevalence and associated risk factors of antenatal depression among women attending antenatal clinics in primary health care centers in the Ministry of Health in Al-Ahsa City, Saudi Arabia,” *Journal of Family Medicine and Primary Care*, vol. 8, no. 12, pp. 3900–3907, 2019. View at: [Google Scholar](#)
19. N. Imran and I. I. Haider, “Screening of antenatal depression in Pakistan: risk factors and effects on obstetric and neonatal outcomes,” *Asia-Pacific Psychiatry*, vol. 2, no. 1, pp. 26–32, 2010. View at: [Publisher Site](#) | [Google Scholar](#)
20. A. F. Dadi, E. R. Miller, T. A. Bisetegn, and L. Mwanri, “Global burden of antenatal depression and its association with adverse birth outcomes: an umbrella review,” *BMC Public Health*, vol. 20, no. 173, pp. 1–16, 2020. View at: [Google Scholar](#)
21. S. Ajinkya, P. R. Jadhav, and N. N. Srivastava, “Depression during pregnancy: prevalence and obstetric risk factors among pregnant women attending a tertiary care hospital in Navi Mumbai,” *Industrial Psychiatry Journal*, vol. 22, no. 1, pp. 37–40, 2013. View at: [Publisher Site](#) | [Google Scholar](#)
22. A. D. Bavle, A. S. Chandahalli, A. S. Phatak, N. Rangaiah, S. M. Kuthandahalli, and P. N. Nagendra, “Antenatal depression in a tertiary care hospital,” *Indian Journal of Psychological Medicine*, vol. 38, no. 1, pp. 31–35, 2016. View at: [Publisher Site](#) | [Google Scholar](#)
23. P. K. Pereira, G. M. Lovisi, D. L. Pilowsky, L. A. Lima, and L. F. Legay, “Depression during pregnancy: prevalence and risk factors among women attending a public

- health clinic in Rio de Janeiro, Brazil," *Cad Saúde Pública*, vol. 25, no. 12, pp. 2725–2736, 2009. View at: [Publisher Site](#) | [Google Scholar](#)
24. D. Govender, S. Naidoo, and M. Taylor, "Antenatal and postpartum depression: prevalence and associated risk factors among adolescents' in KwaZulu-Natal, South Africa," *Depression Research and Treatment*, vol. 2020, 12 pages, 2020. View at: [Google Scholar](#)
25. A. H. Belete, M. A. Assega, A. A. Abajobir, and Y. A. Belay, "Prevalence of antenatal depression and associated factors among pregnant women in Aneded woreda , North West.
26. Т.Мандхай, Б.Батцэцэг, О.Алтанзул, В.Баярмаа. Жирэмсэн үеийн сэтгэл гутрал, түүнд нөлөөлөх зарим эрсдэлт хүчин зүйлс. Сэтгэцийн эрүүл мэндийн алба-90. Эрдэм шинжилгээний бүтээлийн хураангуй. Улаанбаатар хот, 2019:89-94x
27. J. Fisher, M. Cabral de Mello, V. Patel et al., "Prevalence and determinants of common perinatal mental disorders in women in low- and lower-middle-income countries: a systematic review," *Bulletin of the World Health Organization*, vol. 90, no. 2, pp. 139–149H, 2012. View at: [Publisher Site](#) | [Google Scholar](#)
28. Y. A. Belay, N. A. Moges, F. F. Hiksa, K. K. Arado, and M. L. Liben, "Prevalence of antenatal depression and associated factors among pregnant women attending antenatal care at Dubti Hospital: a case of pastoralist region in northeast Ethiopia," *Depression Research and Treatment*, vol. 2018, 9 pages, 2018. View at: [Publisher Site](#) | [Google Scholar](#)
29. G. Ayano, G. Tesfaw, and S. Shumet, "Prevalence and determinants of antenatal depression in Ethiopia: a systematic review and meta-analysis," *PLoS One*, vol. 14, no. 2, pp. 1–11, 2019. View at: [Google Scholar](#)
30. Т.Мандхай<sup>1</sup>, В.Баярмаа<sup>1</sup>, Н.Алтанзул<sup>2</sup>, Л.Насанцэнгэл<sup>1</sup>. Төрсний дараах сэтгэл гутрал, түүнд нөлөөлөх зарим эрсдэлт хүчин зүйлс.. Сэтгэцийн эрүүл мэндийн алба -90. Эрдэм шинжилгээний бүтээлийн хураангуй. Улаанбаатар хот, 2019:178-184
31. Y. D. Wado, M. F. Afework, and M. J. Hindin, "Effects of maternal pregnancy intention , depressive symptoms and social support on risk of low birth weight: a prospective study from southwestern Ethiopia," *PLoS One*, vol. 9, no. 5, pp. 1–7, 2014. View at: [Google Scholar](#)
32. A. Manuscript and C. Pregnancy, *NIH Public Access*, vol. 36, no. 1, pp. 1–14, 2010.
33. W. Getinet, T. Amare, B. Boru, S. Shumet, W. Worku, and T. Azale, "Prevalence and risk factors for antenatal depression in Ethiopia: systematic review," *Depression Research and Treatment*, vol. 2018, 12 pages, 2018. View at: [Google Scholar](#)

34. Kharah M, Ross , Nicole Letourneau , Emma Climie , Gerald Giesbrecht and Deborah Dewey (2020) Perinatal Maternal Anxiety and Depressive Symptoms and Child Executive Function and Attention at Two-years of Age, *Developmental Neuropsychology*, 45:6, 380-382 <https://doi.org/10.1080/87565641.2020.1838525>
35. Leigh B, Milgrom J. Risk factors for antenatal depression, postnatal depression and parenting stress. *BMC Psychiatry*. 2008; 8:24.
36. Belay, S., Astatkie, A., Emmelin, M., & Hinderaker, S. G. (2019). Intimate partner violence and maternal depression during pregnancy: A community-based cross-sectional study in Ethiopia. *PLoS one*, 14(7), e0220003.
37. Alder J, Fink N, Bitzer J, Hosli I, Holzgreve W (2007) Depression and anxiety during pregnancy: a risk factor for obstetric, fetal and neonatal outcome? A critical review of the literature. *J Matern Fetal Neonatal Med* 20:189–209. doi:10.1080/14767050701209560
38. Grote NK, Bridge JA, Gavin AR, Melville JL, Iyengar S, Katon WJ (2010) A meta-analysis of depression during pregnancy and the risk of preterm birth, low birth weight, and intrauterine growth restriction. *Arch Gen Psychiatry* 67:1012–1024. doi:10.1001/archgenpsychiatry.2010.111
39. Van den Bergh BR, Mulder EJ, Mennes M, Glover V (2005) Antenatal maternal anxiety and stress and the neurobehavioural development of the fetus and child: links and possible mechanisms. A review. *Neurosci Biobehav Rev* 29:237–258. doi:10.1016/j.neubiorev.2004.10.007
40. Milapkumar Patel, Rahn K. Bailey, Shagufta Jabeen, Shahid Ali. Postpartum depression: a review. *Journal of health care for the poor and underserved*, Volume 23, number 2, May 2012, pp. 534-542 (article) doi: 10.1353/hpu.2012.0037
41. Pearson RM, Bornstein MH, Cordero M, Scerif G, Mahedy L, Evans J, Abioye A, Stein A (2015) Maternal perinatal mental health and offspring academic achievement at age 16: the mediating role of childhood executive function. *J Child Psychol Psychiatry*. doi:10.1111/jcpp.12483
42. Harvey ST, Pun PK. Analysis of positive Edinburgh depression scale referrals to a consultation liaison psychiatry service in a two-year period. *Int J Ment Health Nurs*. 2007; 16:161–7.
43. Strass P, Billay E. A public health nursing initiative to promote antenatal health. *Canadian Nurse*. 2008; 104:29–33.
44. N. Onunaku, *Improving maternal and infant mental health: focus on maternal depression*, National Center for Infant and Early Childhood Health Policy at UCLA, Los Angeles, CA, 2005.

45. J. Yelland, G. Sutherland, and S. J. Brown, "Postpartum anxiety , depression and social health: findings from a population-based survey of Australian women," *BMC Public Health*, vol. 10, pp. 2–11, 2010. View at: [Google Scholar](#)
46. J. McNamara, M. L. Townsend, and J. S. Herbert, "A systemic review of maternal wellbeing and its relationship with maternal fetal attachment and early postpartum bonding," *PLoS One*, vol. 14, no. 7, article e0220032, 2019. View at: [Google Scholar](#)
47. T. Bitew, C. Hanlon, E. Kebede, G. Medhin, and A. Fekadu, "Antenatal depressive symptoms and maternal health care utilisation: a population-based study of pregnant women in Ethiopia," *BMC Pregnancy and Childbirth*, vol. 16, no. 1, pp. 1–11, 2016. View at: [Google Scholar](#)
48. M. Lodebo, D. Birhanu, S. Abdu, and T. Yohannes, "Magnitude of antenatal depression and associated factors among pregnant women in West Badewacho Woreda, Hadiyya Zone, South Ethiopia: community based cross sectional study," *Depression Research and Treatment*, vol. 2020, 11 pages, 2020. View at: [Publisher Site](#) | [Google Scholar](#)
49. Donna E. Stewart, E. Robertson, M.Phil, Cindy-Lee Dennis, RN, Sherry L. Grace, Tamara Wallington. Postpartum depression: literature review of risk factors and interventions. ©University Health Network Women's Health Program 2003. Toronto Public Health October. 2003; 40-41, 45-47, 54x, 59x.
50. L. Bonari, N. Pinto, E. Ahn, A. Einarson, M. Steiner, and G. Koren, "Perinatal risks of untreated depression during pregnancy," *The Canadian Journal of Psychiatry*, vol. 49, no. 11, pp. 726–735, 2004. View at: [Publisher Site](#) | [Google Scholar](#)
51. M. Sheila and J. E. H. Marcus, "Depression in childbearing women: when depression complicates pregnancy," *Journal of Pediatric and Adolescent Gynecology*, vol. 22, no. 5, pp. 306–312, 2010. View at: [Google Scholar](#)
52. E. Yanikkerem, S. Ay, S. Mutlu, and A. Goker, "Antenatal depression: prevalence and risk factors in a hospital based Turkish sample," *The Journal of the Pakistan Medical Association*, vol. 63, no. 4, pp. 472–477, 2013. View at: [Google Scholar](#)
53. M. Hartley, M. Tomlinson, E. Greco et al., "Depressed mood in pregnancy: prevalence and correlates in two Cape Town peri-urban settlements," *Reproductive Health*, vol. 8, no. 1, pp. 1–7, 2011. View at: [Publisher Site](#) | [Google Scholar](#)
54. Yonas Tesfaye et al., "Antenatal Depression and Associated Factors among Pregnant Women Attending Antenatal Care Service in Kochi Health Center, Jimma Town, Ethiopia" Open Access. Volume 2021 | Article ID 5047432 | <https://doi.org/10.1155/2021/5047432>
55. B. J. V. A. S. Sadock, *Kaplan & Sadock's Synopsis of Psychiatry: Behavioral Sciences/Clinical Psychiatry*, Lippincott Williams & Wilkins, 10th edition, 2007.

56. S. M. Moledina, K. M. Bhimji, and K. P. Manji, "Prevalence and associated factors of depression in an Asian community in Dar es Salaam, Tanzania," *Psychiatry Journal*, vol. 2018, 5 pages, 2018. View at: [Google Scholar](#)
57. G. Gebremichael, M. Yihune, D. Ajema, D. Haftu, and G. Gedamu, "Perinatal depression and associated factors among mothers in Southern Ethiopia: evidence from Arba Minch Zuria health and demographic surveillance site," *Psychiatry Journal*, vol. 2018, 12 pages, 2018. View at: [Publisher Site](#) | [Google Scholar](#)
58. S. Student, "Magnitude of depression and associated factors among Mizan Aman health," *Journal of Psychiatry*, vol. 22, no. 1, pp. 1–6, 2019. View at: [Google Scholar](#)

## Хавсралт 1

### ТАНИУЛСАН ЗӨВШӨӨРЛИЙН ХУУДАС № .....

Танд энэ өдрийн мэнд хүргэе!

**Танилцуулга:** Эрүүл мэндийн яамны захиалгаар Эрүүл мэндийг дэмжих сангийн санхүүжилтээр Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв нь “Жирэмсэн болон төрсний дараах үеийн сэтгэл гутрал түүнд нөлөөлөх зарим эрсдэлт хүчин зүйлсийг тогтоох” сэдвээр судалгааны ажил хийх гэж байна.

**Судалгааны үндэслэл, зорилго:** Дэлхийн олон оронд хийгдсэн тархалтын судалгааны үр дүнгээс харахад жирэмсэн үеийн сэтгэл гутралын тархалт 10-15 хувийг эзэлдэг ба жирэмсний сүүлийн саруудад илүүтэй тохиолддог байна. Жирэмсэн үедээ сэтгэл гутралд өртөх нь нь эх, урагт адилхан сөргөөр нөлөөлдөг. Жирэмсэн эмэгтэй сэтгэл гутралаар шаналах нь ураг зулбах, цагаасаа өмнө төрөх, хожуу үеийн хордлогод өртөх, ургийн өсөлтийн saat ал зэрэг эрсдэлийг нэмэгдүүлдэг бол ирээдүйд мэндлэх хүүхэд жин багатай төрөх, анхаарал дутмагшил хэт хөдөлгөөнтөх эмгэг, импульсив эмгэг, хэл ярианы бэрхшээл, төрх үйлийн эмгэг зэргээр өвчлөх эрсдэлтэй болохыг судлаачид тогтоосон. Иймээс жирэмсэн үеийн сэтгэл гутралын тархалтыг тогтоон, зарим эрсдэлт хүчин зүйлийг илрүүлэн, тусlamж үйлчилгээ үзүүлэх, төрсний дараах үед дагаж хянах, сэтгэцийн эмнэлзүйн үзлэг хийх шаардлагатай байгаа нь бидний судалгаа хийх үндэслэл болж байна.

**Судалгааны ерөнхий танилцуулга:** Судалгааны ажил 2022 оны 02 дугаар сараас 2023 оны 03 дугаар сар хүртэл үргэлжлэх ба бид Улаанбаатар хотын Сонгинохайрхан, Баянзүрх, Багануур, Чингэлтэй дүүргийн эмнэлэг, Баруун, Төв, Хангай, Зүүн бүсийн аймгуудын жирэмсний хяналтанд хянагдаж буй 6-40 долоо хоногтой жирэмсэн эмэгтэйчүүдийг судалгаанд хамруулна. Судалгаанд оролцогчдод таниулсан зөвшөөрлийн хуудсыг танилцуулж, зөвшөөрөл авах ба хүн ам зүйн, одоогийн болон өмнөх жирэмслэлтийн тухай, сэтгэл гутралыг үнэлэх асуумж хуудсыг бөглүүлнэ. Төрсний дараах 3 сард сэтгэл гутралыг сонгогдсон оролцогчид дахин үнэлнэ. Сэтгэл гутралтай тохиолдолд сэтгэцийн эмч эмнэлзүйн үзлэг хийж зөвлөгөө өгнө.

**Эрсдэл:** Та уг судалгаанд оролцсон тохиолдолд мэдээллийн нууцлал алдагдсанаас таны нэр хүндэд сөргөөр нөлөөлж болзошгүй тул эрсдэлээс сэргийлж таны талаарх мэдээллийг чанд нууцлан, найдвартай хадгална. Судалгааны мэдээллийг ашигласны дараа картыг найдвартай аргаар устгана.

**Ашиг тус:** Та энэ судалгаанд оролцсоноор танд сэтгэл санааны ямар нэгэн тулгамдсан асуудал байгаа эсэхээ үнэлүүлэх боломжтой бөгөөд судалгааны багийн гишүүдээс сэтгэлзүйн тусlamж авах боломжтой.

**Урамшуулал:** Судалгаанд оролцсон тохиолдолд оролцогчоос ямар нэгэн төлбөр авахгүй, судалгааны багийн зүгээс таньд судалгаанд оролцсоны урамшуулал 5000 төгрөг олгоно. Шинжилгээ хийгдсэн болон төрсний 3 сарын дараа судалгаанд оролцсон тохиолдолд мөн ахин 5000 төгрөг олгоно.

**Нууцлал:** Судалгаанд оролцогчийн хувийн мэдээллийг нууцалж, судалгаанаас

гарсан үр дүнг зөвхөн эрдэм шинжилгээний зорилгоор ашиглана.

**Судалгаанд оролцогчийн эрх:** Судалгааны талаар бүрэн мэдээлэл авах эрхтэй. Та судалгаанд өөрийн зөвшөөрлөөр оролцох бөгөөд судалгааны аль ч үед судалгаанаас гарах эрхтэй. Та судалгаанд оролцохгүй байх эрхтэй.

Би дээрх мэдээлэлтэй танилцаж, судалгааны талаар (зорилго, ач холбогдлыг) ойлгосон тул судалгаанд оролцохыг зөвшөөрч байна. Би гарын үсэг зурснаар судалгаанд өөрийн хүсэлтээр оролцож байгаагаа илэрхийлж байна. Мөн надад энэхүү таниулсан зөвшөөрлийн хуудаснаас нэг хувийг өгсөн.

Судалгаанд      оролцогчийн      овог.....      нэр

.....

Гарын үсэг.....

Та      хүсвэл      хаяг,      утасны      дугаараа      бичнэ

YY.....

**Он, сар, өдөр:** 202.....оны.....сарын.....өдөр

**Холбоо барих хаяг:**

Судлаач, СЭМҮТ-ийн    ДЭСК-ийн тэргүүлэх зэргийн эмч    Л.Насанжаргал  
(88012009)

Имэйл хаяг: njl\_9999@yahoo.com

## Хавсралт 2

### СУДАЛГААНЫ КАРТ № .....

Асуумжинд үнэн бодитой хариулт өгч бидний ажилд туслалцаа үзүүлнэ гэдэгт гүнээ найдаж байна. Та доорхи асуултуудыг анхааралтай уншиж, хариулахдаа сонгосон хариултаа ✓ тэмдэглэгээ хийх, дугуйлахаас гадна зарим асуултанд дэлгэрэнгүй хариулж бичнэ үү. Таны өгсөн мэдээллийн нууцыг чандлан хадгална.

#### **А ХЭСЭГ: ЕРӨНХИЙ АСУУМЖ**

№	Асуултууд	Дэд асуултууд	Хариулт
<b>1. Хүн ам зүйн мэдээлэл</b>			
1.1	Судалгаанд оролцогчийн код (Судлаач бичиж өгнө)		
1.2	Харилцах утасны дугаар		
1.3	Нас		
1.4	Харьяалал /хаяг/	<input type="checkbox"/> Улаанбаатар .....дүүрэг .....хороо  <input type="checkbox"/> Хөдөө, орон нутаг .....аймаг .....хороо .....сум	
1.5	Мэргэжил		
1.6	Та боловсролынхоо дээд түвшинг нэрлэнэ үү?	<input type="checkbox"/> Бичиг үсэгт тайлгадаагүй <input type="checkbox"/> Бичиг үсэгт тайлгадсан <input type="checkbox"/> Бага <input type="checkbox"/> Бүрэн бус дунд <input type="checkbox"/> Бүрэн дунд <input type="checkbox"/> Тусгай дунд/коллеж <input type="checkbox"/> Дээд <input type="checkbox"/> Төгсөлтийн дараах боловсрол (Магистр, доктор)	
1.7	Таны яс үндэс	<input type="checkbox"/> Халх <input type="checkbox"/> Бусад (Бичих.....)	
1.8	Сүүлийн 12 сарын хугацаанд таны эрхэлж байсан үндсэн ажил юу вэ?	<input type="checkbox"/> Төрийн байгууллага <input type="checkbox"/> Төрийн бус байгууллага <input type="checkbox"/> Хувиараа хөдөлмөр эрхэлдэг <input type="checkbox"/> Тогтмол цалингүй, цагийн ажил хийдэг <input type="checkbox"/> Оюутан <input type="checkbox"/> Гэрийн ажилтай <input type="checkbox"/> Ажилгүй (ажлын чадвартай) <input type="checkbox"/> Хөдөлмөрийн чадвараа алдсан тул группд байдаг <input type="checkbox"/> Малчин	

		Огт гэрлэж байгаагүй ганц бие ээж	<input type="checkbox"/>	
1.9	Таны гэр бүлийн байдал	Гэрлэсэн (хууль ёсны гэр бүлтэйгээ хамт амьдардаг)	<input type="checkbox"/>	
		Тусдаа амьдарч байгаа (гэр бүл салаагүй ч )	<input type="checkbox"/>	
		Салсан (ганц бие ээж)	<input type="checkbox"/>	
		Бэлэвсэrsэн	<input type="checkbox"/>	
		Хамтран амьдрагчтай	<input type="checkbox"/>	
1.10	Өмнө өөр гэр бүлтэй байсан эсэх (Тийм бол хэд дэх гэрлэлт болохыг тодруулж бичнэ үү?)	..... ..... ....	<input type="checkbox"/>	
1.11	Танай өрхийн сарын орлого хэд вэ?	.....(төгрөгөөр,тоогоор бичнэ үү?)	<input type="checkbox"/>	
1.12	Таны өөрийн сарын орлого хэд вэ?	.....(төгрөгөөр,тоогоор бичнэ үү?)	<input type="checkbox"/>	
1.13	Та хэдэн хүүхэдтэй вэ?	.....тоогоор бичих	<input type="checkbox"/>	
1.14	Ам бүлийн тоо	.....тоогоор бичих	<input type="checkbox"/>	
1.15	Гэр бүлийн харилцаа <b>(хэдэн ч хариулт сонгож болно)</b>	Тайван амгалан санаа зовох зүйлгүй Нөхрийн зүгээс сэтгэл санаа, эдийн засгийн дэмжлэг дутмаг Нөхөртэйгөө харьцаа сайтай боловч хадам эцэг эхийн оролцоо хэт их байдаг нь хэцүү байдаг Нөхөртэйгөө харьцаа сайтай боловч миний өөрийн эцэг эхийн оролцоо хэт их байдаг нь хэцүү байдаг Нөхөр ажил хийдэггүй тул маргалдах зүйл их гардаг Нөхөр архи ууж агсан тавьдаг тул айдаг Нөхөртэйгөө ойлголцож чаддаггүй ч бусад хүмүүсийн нүдэнд эв найртай гэр бүл шиг харагддаг Эв түнжин муутай байдаг Гэр бүл, найз нөхдийн зүгээс тусlamж дэмжлэг багатай	<input type="checkbox"/> <input type="checkbox"/>	
1.16	Дээр дурдсанаас өөр ямар нэгэн саад бэрхшээл байдаг бол бичнэ үү? Хэрэв байхгүй бол алгасна уу?	..... ..... ...	<input type="checkbox"/>	
1.17	Одоогоор ямар нэгэн хүчирхийлэд өртөж байгаа эсэх <b>(хэдэн ч хариулт сонгож болно)</b>	Ямар нэгэн хүчирхийлэлд өртөөгүй Бие махбодын хүчирхийлэлд өртдөг Эдийн засгийн хүчирхийлэлд өртдөг Сэтгэл санааны хүчирхийлэлд өртдөг	<input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/>	

		Үл хайхрах хүчирхийлэлд өртдөг	<input type="checkbox"/>	
		Бэлгийн хүчирхийлэлд өртдөг	<input type="checkbox"/>	
		Бусад	<input type="checkbox"/>	
1.18	Дээр дудсан хүчирхийлээс өөр ямар нэгэн хүчирхийлэлд өртсөн бол бичнэ үү?	..... ..... ....	<input type="checkbox"/>	
